МАНАЙ СОНИНЫ II УЛИРЛЫН НЭМЭЛТ ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,136.996... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.04.11. Мягмар. №071 (4685) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




УЛС ТӨР

Б.ЖАВХЛАН: ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ БАНКНЫ САЛБАРУУДЫГ ДАГАЖ ЭДИЙН ЗАСГИЙН ТАГНУУЛ ОРЖ ИРЭХИЙГ ҮГҮЙСГЭХГҮЙ, ГЭХДЭЭ...

II нүүрт

ДЭЛХИЙ

ОРОСЫН МЕТРОНД БОЛСОН ДЭЛБЭРЭЛТ УЧИР БИТҮҮЛЭГ ХЭВЭЭР БАЙНА

VI нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

## ОРОН СУУЦНЫ ҮНИЙГ БУУРУУЛАХ АРГА БАЙНА



Н.ПУНЦАГБОЛД

Улаанбаатар хотын тулгамдсан асуудлуудыг тоочоод барагдахгүй. Агаар, орчны бохирдол хэрээс хэтэрчихсэн. Хөрсний бохирдол, хог хаягдал ч дийлдэхээ больсон. Нийслэлийн гэр хороололд 200 гаруй мянган өрх амьдарч, задгай жорлонд бие засч, хөрсийг бохирдуулж байна. Цаашлаад өдөртөө хэчнээн зуун мянган тонн угаадсыг шууд хөрс рүү асгаж байгаа.

**Үргэлжлэл нь III нүүрт**

Дугаарын 60 мөр

## Дарга нарын давралыг хуулиар хязгаарлаач

Н.БОЛД

Монгол Улс парламентын тогтолцоотой, ардчилсан орон. Парламентын тогтолцоотой дэлхийн бүхий л оронд Ерөнхий сайд нь эрх мэдлээ гартаа атгаж, хүмүүсээ томилж, өөрчилж, шинэчилдэг. Харин манайд бол Ерөнхий сайд, Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, цаашлаад 76 гишүүн, салбарын сайдууд гээд эрх мэдэл түм бум хуваагдчихсан. Төлөөллийн ардчиллыг хэрэгжүүлж буй гэдэг ч иргэдийн сонгосон түшээд нь сонгуулийн маргаашаас эрх мэдлийн төлөөх “дайн” хийгээд явчихдаг. Юун хэсэг бүлэг хүмүүсийг төлөөлж төрд ажиллах, тэр тухай санадаг хүн манайд нэг ширхэг ч байхгүй. За тэгээд нэг дарга, сайд болоод авбал очсон газраа шоргоолжны үүр эвдэж байгаа аятай л самарна даа.

**Үргэлжлэл нь III нүүрт**




ОНЦЛОХ МЭДЭЭ

## Сүүлийн дөрвөн жил тасраад байсан аяллыг УБТЗ-ын “Аялал жуулчлалын товчоо” эхлүүлнэ

Улаанбаатар төмөр замын “Аялал жуучлалын товчоо” Хөх хотын төмөр замын Олон улсын аялал жуулчлалын товчоотой Хил орчмын аялал жуулчлалын хамтын ажиллагаа эхлүүллээ. “Өдрийн жуулчин” болон “Улаанбаатар- Горхи Тэрэлж”, Хархорин, Хөвсгөл, Хамрын хийд гэсэн дөрвөн чиглэлийн уртасгасан маршрутаар 2017 ондоо нийт 3000 жуулчин авах гэрээнд Улаанбаатар төмөр замын “Аялал жуучлалын товчоо”-ны захирал Б.Хажидмаа, Хөх хотын төмөр замын орлогч дарга Чөн Бө нар гарын үсэг зурсан байна. Монгол Улсын Засгийн газрын Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилтын хүрээний ажлын гараа ийнхүү эхэллээ. Гэрээний дагуу ирэх 21-ний өдрөөс эхлэн арваннэгдүгээр сарын 01-нийг хүртэл долоо хоногт хоёр удаа тус бүр 100 “Өдрийн жуулчин” Замын-Үүд сумаар аялахдаа Улаанбаатар төмөр замын “Аялал жуулчлалын товчоо”-ны харьяа “Жинчин” төв болон “Дорнын говь-1”




жуулчны баазаар үйлчлүүлж, Монголын уламжлал, зан заншилтай танилцах, үндэсний соёл урлагийн тоглолт үзэж, “Жинчин” төвд шинээр үүд хаалгаа нээж буй “MADE IN MONGOLIA” дэлгүүрээс худалдан авалт хийх аж. “Өдрийн жуулчин” гэдэг нь хамтрагч хоёр талын тохиролцсон маршрутын дагуу аялаад тухайн өдөртөө багтаж, хил даван буцах богино хугацааны жуулчид юм. Улаанбаатар төмөр замын “Аялал жуулчлал”-ын товчоо ийнхүү Замын-Үүдээр нэвтрэх “Өдрийн жуулчин”-ы урсгалыг эхлүүлээд зогсохгүй Дорноговь аймгийн Аялал жуулчлалын газар Эрээн хотын Аялал жуулчлалын танхимын түншлэлийн шугамаар ирэх жуулчдаас ч дийлэнхийг нь хүлээн авч ажиллах төлөвтэй байгаагаа Б.Хажидмаа захирал хэлжээ. Тус гэрээг үзэглэхэд Хөх хотын төмөр замын орлогч дарга Чөн Бө, Гадаад харилцааны дарга Ван Хөн Ли, Төмөр замын тээвэрлэлт хариуцсан дарга Хао Чүн Вөн, Борлуулалт хариуцсан эрхлэгч Шин Жиэн Мин нар оролцсон нь БНХАУ-ын тал аялал жуулчлалын салбартаа ихээхэн ач холбогдол өгч буйг илэрхийлэв. Хөх хотын төмөр замын орлогч дарга Чөн Бө “Аялал жуулчлалаа хөгжүүлэхийн тулд бид маш их хөрөнгө оруулалт хийж, бэлтгэл хангаж байна. Эртний сайхан харилцаатай ч сүүлийн дөрвөн жил тасраад байсан аяллын замаа хоёр талын хамтын шаргуу хүчин зүтгэлээр энэ зунаас эхлүүлэн нээж байгаадаа баяртай байна...” гэжээ.




| | ХААН банк | | | | | Худалдаа хөгжлийн банк | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Авах | Зарах | | Авах | Зарах | | Авах | Зарах | | Авах | Зарах |
| АМ.ДОЛЛАР | 2416.00 | 2430.00 | ФУНТ | 29853.00 | 3046.00 | АМ.ДОЛЛАР | 2414.00 | 2424.00 | ФУНТ | 2958.00 | 3029.00 |
| ЕВРО | 2527.00 | 2593.00 | РУБЛЬ | 41.20 | 43.20 | ЕВРО | 2527.00 | 2590.00 | РУБЛЬ | 40.398 | 43.98 |
| ИЕН | 21.60 | 21.91 | ЮАНЬ | 348.50 | 352.50 | ИЕН | 21.452 | 21.97 | ЮАНЬ | 349.00 | 351.90 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

ШАР МЭДЭЭ

## МоАН, Нэг ардчилал нэгдсэн үү

Ардчиллын төлөөх таван нэгдэж, Ардчилсан намыг байгуулсан түүхэн ой өнгөрөгч баасан гарагт болов. "Ардчиллын алтан хараацай" гэгдэх ардчилсан партизанууд, шинэ цагийн АН-ын залуу гишүүд энэ өдөр баяраа ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлэв. Таван намын нэгдэл өнөөдрийн улс төрд шинэ жишиг тогтоож чадаагүй ч зарим талаараа дотоод ардчилал ил тод, зөрчил маргаанаа хайцаалдаггүй гэх мэтээр эерэг мессеж өгөх нь ч бий. Юутай ч таван нам нь таван фракци болон өөрчлөгдсөн АН-ынхан сонгуулийн түүхэндээ хоёр ч удаа том ялагдал хүлээгээд байгаа. 1996 оны их ялалтын дараа ялагдал, 2012 оны үнэмлэхүй олонхийн ялалтын дараах ялагдлын дараа АН-ынхан бидний ялагдал фракцийн улс төрөөс болсон гэсэн дүгнэлт хийсэн юм. Тиймдээ ч намын даргаасаа эхлээд фракцигүй улс төрийн нам болох зорилго тавьсан. Харамсалтай нь тэгж чадаагүй. Өнөө хэр АН-д фракцийн улс төр амь бөхтэй оршиж байна. Тэгвэл ойрноос сүүлд байгуулагдсан хоёр фракци нэгдсэн гэх мэдээлэл явж эхэллээ. Тодруулбал, УИХ-ын гишүүн асан Х.Тэмүүжин, Лу.Гантөмөр нарын байгуулсан "Нэг ардчилал", УИХ-ын гишүүн асан А.Бакей, Г.Батхүү, Ц.Оюунгэрэл нарын байгуулсан МоАН фракци нэгдсэн бололтой. Хэрвээ энэ мэдээлэл үнэн бол АН-ынхан таван хүчирхэг фракцитай болж байна. АН-д МоАХ, Алтангадас, Шонхор, МҮДН гэсэн дөрвөн хүчирхэг фракци бий. Тэгвэл эдгээр дөрөв дээр МоАН фракци нэмэгдсэнээр эрх мэдлийн төлөөх тулаан таван хүчтэй фракцийн дунд өрнөх нь тодорхой болж байна. Залуу гишүүдийн сонголт зөв байсан эсэхийг хэлэхэд эрт байгаа ч Ардчилсан намын фракци нэгээр ч болов хорогдож байгаа нь сайшаалтай хэрэг юм.

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч:
С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч
Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:
Э.ЭНХЦЭЦЭГ
90873012

Ахлах редактор:
Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба
Н.ПУНЦАГБОЛД
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба:
Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Гэрэл зургийн алба:
Г.АРГУУЖИН
96017873

Компьютерийн алба:
Б.ГАНЗОРИГ
99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба:
Н.АЛТАНЦЭЦЭГ
99173710

Захиалга, борлуулалтын алба:
М.ДАВААДУЛАМ
99042510

Э.САЙНЗАЯА
99197866

Дугаарыг эрхэлсэн
Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/.
2 давхар. 209, 211 тоот

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

МАН-ИЙН ТОДРУУЛГА



# Б.ЖАВХЛАН:

## ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ БАНКНЫ САЛБАРУУДЫГ ДАГАЖ ЭДИЙН ЗАСГИЙН ТАГНУУЛ ОРЖ ИРЭХИЙГ ҮГҮЙСГЭХГҮЙ, ГЭХДЭЭ...

Ж.ОТГОН

*УИХ дахь МАН-ын бүлэгийн өчигдрийн ээлжит хуралдаанаараа Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төслийг хэлэлцлээ. Үүнтэй холбоотойгоор УИХ-ын гишүүн Б.Жавхлангаа зарим зүйлийг тодруулаа.*

**-Хөрөнгө оруулалтын банкны тухай хууль энэ долоо хоногийн УИХ-ын чуулганы хэлэлцэх асуудлын дунд байна. Энэхүү хуулийг хаврын чуулганы хүрээнд баталчихвал гадаадын банкууд манай улсад салбараа нээх эрх зүйн орчин бүрдэнэ гэж хүмүүс ойлгоод байгаа. Энэ хуульд орох гол өөрчлөлтүүд юу байгаа вэ?**

-Хөрөнгө оруулалтын банкны тухай хууль оны өмнөхөн өргөн баригдсан. Хуулийн төслийг энэ долоо хоногоос эхлэн хэлэлцэнэ. Өнөөдөр /өчигдөр/ бүлгийн хурлаар танилцуулга хийлээ. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа банкны тухай хуулийн гадаадын банкны салбар нэгж гадаадын хөрөнгө оруулалттай банк байгуулж, үйл ажиллагаагаа явуулах нь нээлттэй байгаа. Өөрөөр хэлбэл, хориглосон зохицуулалт байхгүй. Одоо манайд үйл ажиллагаа явуулж байгаа 13 банкны найм нь их бага хэмжээгээр гадаад иргэн, гадаадад бүртгэлтэй аж ахуйн нэгж хуулийн этгээдийн хөрөнгө оруулалттай. Манай үндсэн том гурван банк буюу "ХААН", "Голомт", "Худалдаа хөгжлийн банк" гадаад улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалттай байх жишээтэй. Тиймээс шинэ хуулиар гадаадын хөрөнгө оруулалттай банкуудыг шинээр зохицуулалт хийгээд гадаадын банкны салбар Монголд орж ирээд үйл ажиллагаа явуулах нь хаалттай байсан зүйлийг нээлттэй болгож байгаа зохицуулалт огтоос биш. Тухайлбал, одоо хэрэгжиж байгаа хуулийн хүрээнд Оросын банкны салбар манайд үйл ажиллагаагаа явуулж байсан. Харин оросдоо толгой банк нь байхгүй болоод манайд явуулж байсан үйл ажиллагаагаа зогсоосон. Тэгэхээр энэ хуулиар цоо шинэ эдийн засгийн харилцааг зохицуулах гээд байгаа асуудал ерөөсөө биш. Харин гадаадын хөрөнгө оруулалттай томоохон банкууд орж ирсэн тохиолдолд дотоодын банкуудтай хүч тэнцвэргүй банкны өрсөлдөөн бий болж болзошгүй эрсдлээс хамгаалж, хуулийн зохицуулалтыг хийх гэж байгаа юм. Тиймээс ч Хөрөнгө оруулалтын банкны тухай хууль банкны тухай хуулиасаа тусдаа батлагдаж буй. Ийнхүү гадаадын хөрөнгө оруулалттай банкны салбар нэгжүүд манайд ажиллахдаа ямар салбар дээр ажиллах вэ гэдгийг тодорхой зааглаж өгсөнөөрөө эрсдлүүдийг хамгаалах бүрэн боломжтой болно.

**-Гадаадын хөрөнгө оруулалттай банкны салбаруудыг дагаж банкуудын хүч тэнцвэргүй өрсөлдөөнөөс гадна өөр эрсдэлүүд гарна гээд байх юм?**

-Хүмүүсийн ярьж байгаа шиг өөр эрсдэлүүд байж болзошгүй. Тухайлбал, Гадаадын хөрөнгө оруулалт банкны салбаруудыг дагаж, мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэх, гиопилитикийн довтолгооны, эдийн засгийн тагнуулийн зэрэг эрсдэл байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ бид үүнтэй тэмцэхийн тулд олон улсын сатандартад нийцсэн хууль эрх зүйн тогтолцоог сайжруулах, дотоодын хууль хүчний байгууллагуудыг илүү сайжруулах, чанаржуулах арга хэмжээг авах хэрэгтэй. Гэтэл үүний оронд зах зээлээ гээд бүх зүйлээ хааж хаячихаад, суугаад байх нь асуудлыг шийдэх оновчтой арга биш гэж үзэж байна. Гадаадын хөрөнгө оруулалттай санхүүгийн байгууллагууд орж ирснээр гарах сайн үр дагаварууд олон байгаа. Өнөөдөр манайд хамгийн их дутагдалтай байгаа гадаад валют, капиталын урсгал нэмэгдүүлэх бүрэн боломж нээгдэнэ. Дээрээс нь 4-5 жилийн өмнө манай эдийн засаг хамгийн өндөр өсөлттэй байсан үеийнх шиг манай зах зээл олон улсын сонирхол татахаар биш байгаа. Харин энэ хуулийг баталснаар гадаадын банкуудыг, гадныг хөрөнгө оруулалттай санхүүгийн байгууллага хаала тогшоод ороод ирэх нөхцөл байхгүй байгаа. Тэглээ гээд энэ асуудлыг хойшлуулж болохгүй. Энэ өөрөөр дунд хугацаандаа 8-10 жилийн хугацаатай шилжилтийн бүтцийн өөрчлөлтийн процесс учир хугацаа алдалгүй эхлүүлэх нь чухал. Тиймээс ч Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийг энэ хаврын чуулганаар зайлшгүй хэлэлцэж нэг тийш нь болгох хэрэгтэй гэж үзэж байгаа.

**-Хуулийн төсөлд гадны банк орж ирвэл яг аль салбарт хөрөнгө оруулахаар тусгасан байгаа вэ?**

-Манай банкны систем өөрөө өрөөсгөл шинжтэй явж ирсэн. Технологи талаасаа бол сайжирч байна. Гэхдээ сүүлийн 25 жил хоёр шатлалтай болж ирснээрээ арилжааны банкууд зөвхөн хадгаламж дээр өрсөлддөг. Тэр хэрээрээ хадгаламжийн хүү өндөр байх тусмаа бусад санхүүгийн зуучлалын өртгүүд буурах ямар ч боломжгүй байгаа юм. Тэгэхээр үүнийг задалж, банкны системд төвлөрчихөөд байгаа мөнгөний урсгалыг хөрөнгийн зах зээл рүү чиглүүлэх нь бодлогын цөм байх учиртай. Хөрөнгө оруулалтын банкууд энэ чиглэл рүү илүү үйл ажиллагаа явуулах учиртай. Гол зааглаж байгаа зүйлүүд гэвэл хөрөнгө оруулалтын чиглэлээр ажиллах банк нь гадаадаас олон улсын санхүүгийн зах зээл дээрээс өөрсдөө хөрөнгөө авч ирж, манай зах зээл рүү нийлүүлэх ёстой. Түүнээс манай дотоодын банкууд ажилладаг хадгаламжийн зах зээл рүү ороод, бусад банктай өрсөлдөөд хадгаламжийн хүүг өсгөж, тэтгэврийн зээл өгөхгүй. Энэ бүгдийг хориглож, зааглаж өгнө. Магадгүй 100 тэрбум төгрөгөөс дээш санхүүжилт шаардсан урт хугацааны хөрөнгө оруулалттай төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлж болно. Мөн дотоодын банкны дүрмийн сангийн доод хэмжээ 50 тэрбум байхад хуулийн төсөл дээр гадаадын хөрөнгө оруулалттай банк Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулах юм бол дүрмийн сан 500 тэрбумаас доошгүй байна гэх зэргээр зах зээлийг нь зааглаж өгсөн зохицуулалт хийж байна. Ер нь бол хамгийн эхний зорилго дотоодын банкны зээ зээлийг хамгаалах. Дээрээс нь том бизнес эрхлэхэд шаардлагатай мөртлөө дотоодын банкууд өгч чадахгүй байгаа мөнгийг оруулж ирэхийг зорьсон.

**-Эдийн засагч хүний хувьд та энэ удаагийн төсвийн тодотголын тал дээр ямар байр суурьтай байна вэ ?**

-Дан ганц төсөв гэдэг утгаараа биш ОУВС-тай хамтарч ажиллана гэдэг утгаараа тодотголоор орж ирж байгаа асуудлуудыг дэмжиж байгаа. Уг нь хаврын чуулган эхлэхээс өмнө ээлжит бус чуулган зарлаад явсан бол бүр их хугацаа хожих байсан. ОУВС-ийн эхний ээлжийн санхүүжилт болон манайхтай хамтарч ажиллахаа илэрхийлсэн олон улсын байгууллагуудын мөнгө ороод ирчихсэн байх байлаа.

**-Төвийн тодотголтой холбоотойгоор бизнес эрхлэгчид татвар нэмэхийн эсэргүүцэж эхэллээ. Татвар нэмснээр гарах сөрөг үр дагавар юу байна вэ?**

-Төсвийн тодотголоор оруулж ирж байгаа татваруудад бизнес эрхлэгчдэд шууд нөлөөлж байгаа татвар байхгүй. Харин шууд нөлөөлөх асуудал гэвэл нийгмийн даатгал л байгаа. Гэхдээ нийгмийн даатгалын асуудал эрт орой хэзээ нэгэн цагт хөндөгдөх л байсан. Манай нийгмийн даатгалын тогтолцоо 2000 оноос хойш буруу явж ирсэн. Өнөөдрийн төлж байгаа нийгмийн даатгалын шимтгэлээр тэтгэврийг тавьж байгаа. Уг нь бол нийгмийн даатгалын шимтгэлээр нийгмийн даатгалын сан арвижиж байх ёстой. Гэтэл ямар ч мөнгөгүй болсон. 2020-2030 онд тэтгэвэр авагчдын тоо нэмэгдэх хүлээлт бий. Тэр үед нийгмийн даатгалын сан мөнгөгүй болно. Тэгэхээр бидний татвараар төлдөг мөнгөөр тэтгэвэр тавих тогтолцоо руу шилжих нөхцөл үүсэх учраас даатгалын санд мөнгө хуримтлуулж байх ёстой. Төсвийн тодотголын хувьд миний эргэлзэж байгаа зүйл бол хадгаламжийн хүүнээс татвар авах асуудал. Хуулийн зохицуулалтаар 2018 оноос хэрэгжих байсан ч наашлуулчихлаа. Уг нь хадгаламжийн хүүгийн татварыг эдийн засгийн өсөлттэй үед авдаг. Гэтэл эдийн засгийн хүндрэлтэй үед авч байгаа нь хугацааны хувьд буруу болчихоод байна. Хадгаламжийн татварын хүү олон улсад хэрэглэгддэг зарчмаараа бол төсвийн орлогыг бүрдүүлдэг гэхээсээ илүүтэйгээр төсвийн бодлогын зохицуулалтын арга хэмжээ буюу хэт банкны системд төвлөрсөн хөрөнгийн урсгалыг үнэт цаас зэрэг өөр зах зээл рүү оруулахад түлхэц болдог.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## "Хөгжлийн хөтөч Булган" форум боллоо




"Хөгжлийн хөтөч Булган" эдийн засгийн форум өнгөрсөн амралтын өдрүүдэд Булган аймагт боллоо. УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Бүгд Найрамдах Турк улсын ТИКА Олон улсын байгууллагын Улаанбаатар хот дахь хөтөлбөрийн ерөнхий зохицуулагч Вэйсэл Чифтжи, ОХУ-ын Красноярскийн ХАА-н сургуулийн эрдэмтэд, Улаанбаатар хотоос салбар яамдын төлөөлөл болон судалгааны байгууллагынхан, Булган, Эрдэнэт, Дархан, Улаанбаатар зэрэг хот хөдөөгийн бизнесменүүд, аймаг орон нутгийн удирдлагууд гээд өргөн бүрэлдэхүүнтэй хуралдлаа. Уг форумаар тус аймгийн эдийн засгийн байдал, бизнесийн орчин нөхцөл, боломж бололцоонд судлаачид, оролцогчид үнэлэлт дүгнэлт өгч, орон нутгийн удирдлагууд хамтран ажиллах нөхцөл шаардлага, хөгжлийн чиг хандлагын талаар мэдээлэл өгсөн бол орологчид дөрвөн үндсэн салбар чиглэлээр хэлэлцүүлэг явуулан хөгжлийн хөтөч болсон салбар чиглэлүүдээ тодорхойлсноороо давуу талтай болсон байна. Энэ үеэр УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ "Салбар бүрээр үйлдвэрлэлийн чиглээ зөв тодорхойлох, ойролцоох аймгууд болон томоохон хотуудын худалдан авалтад түшиглэсэн үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжих хэрэгтэй байна. Цаашлаад олон улсын зах зээлд гарах боломж бололцоог судлаж хамтын ажиллагааг эхлүүлэхэд анхаарч ажиллаарай" хэмээгээд өөрийн зүгээс бүх боломж бололцоогоороо дэмжин ажиллахаа дуулгав. Тэрбээр мах сүүний чиглэлээр дотоодын төдийгүй гадаад зэх зээл нээлттэй байна. Чацаргана гэхэд худалдан авах, мөн эцсийн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ дотооддоо төдийгүй Японы зах зээлд нээлттэй байна. Захиалгаа өгч байна. Гол нь иргэд, бизнес эрхлэгчид хамтран гарцаа зөв тодорхойлох, нэгдэж ажиллах шаардлагатай. Тариа тарихад тархиндаа эхлээд ургуулаа гэдэг шиг бид хөгжлийн тариагаа тархиндаа ургуулж, ургуулсан тариагаа цэцэглүүлэх л үлдээд байна гэдгийг энэ үеэр онцоллоо.

## Элчин сайд О.Оч итгэмжлэх жуух бичгээ өргөн барив

Монгол Улсаас Европын Холбооны дэргэд суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Одын Оч Европын Холбооны Зөвлөлийн Ерөнхийлөгч Дональд Тускд энэ сарын 07-ны өдөр Итгэмжлэх жуух бичгээ өргөн барив. Итгэмжлэх Жуух Бичгээ барьсантай нь холбогдуулж Ерөнхийлөгч Д.Туск Элчин сайд О.Очийг хүлээн авч уулзаж, Монгол Улс-Европын Холбооны харилцаа, хамтын ажиллагааны талаар ярилцаж, санал солилцов. Уулзалтын үеэр Элчин сайд О.Оч Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн мэндчилгээг Европын Холбооны Зөвлөлийн Ерөнхийлөгч Д.Тускд уламжилж өнгөрсөн жил Улаанбаатар хотноо болсон АСЕМ-ын Дээд хэмжээний 11 дүгээр уулзалтад Ерөнхийлөгч Д.Туск биечлэн оролцсонд талархал илэрхийлжээ. Түүнчлэн Европын Холбоо нь Монгол Улсын гадаад бодлогод чухал ач холбогдолтой "Гуравдагч хөрш"-ийн нэг болохыг тэмдэглэхийн зэрэгцээ монголын тал цаашид Европын Холбоотой Иж бүрэн түншлэлийг хөгжүүлэхийг зорьж Европын Холбоо болон түүний гишүүн орнуудтай харилцаагаа гүнзгийрүүлэн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх сонирхолтой байгааг цохон тэмдэглэв. Европын Холбооны Зөвлөлийн Ерөнхийлөгч Д.Тускд өнгөрсөн жил Улаанбаатар хотноо болсон АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтад оролцож сэтгэгдэл өндөртэй буцаж ирсэн тухайгаа дурдаад Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржид мэндчилгээ уламжилсан байна. Тэрбээр Монгол Улс ардчиллын үндэс суурийг баттай тавьж ардчиллын үндсэн зарчмуудыг бодит утгаар нь өдөр тутам хэрэгжүүлж байгааг дурдаад Монгол Улс бол Европын Холбооны хувьд Холбооны гаднах чухал түнш орнуудын нэг болохыг цохон тэмдэглэв. Чингэхдээ Монгол Улс эдийн засгийн хувьд хүнд үеийг туулж байгаа ч ардчиллын зарчмуудад туушгай байгааг Европын Холбоо өндөрөөр үнэлж цаашид Европын Холбоо Монгол Улс хоорондын бодит хамтын ажиллагааг бэхжүүлэхийн төлөө байгаагаа илэрхийлсэн байна.

## ҮЗЭЛ БОДОЛ

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ

# ОРОН СУУЦНЫ ҮНИЙГ БУУРУУЛАХ АРГА БАЙНА

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Мөн өвөлдөө гудамжинд гаргаж асгаж байгаа үнсийг нь хэчнээн тонн болохыг ч тоочих арга байхгүй. Энэ бүх асуудлаас гарах арга зам нь, утаанаас салах гарц нь орон сууцжуулах. Цаашлаад гэр хорооллыг дахин төлөвлөх, төвийн шугамд холбох арга байна. Гэхдээ манай улсын дулаан, эрчим хүчний чадал ямархуу хэмжээнд байгаа билээ. Гэр хорооллын хэдэн айл цахилгаанаар халаалтаа шийдэх гэхээр чадал нь хүрэхгүй, халааж дийлэхгүй байгаа шүү дээ. Тийм болохоор хамгийн нэн түрүүнд шийдэх гарц нь ерөөсөө л орон сууцжуулах. Одоогоор Улаанбаатар хотын иргэдийн 30 гаруйхан хувь нь л тохилог орон сууцанд амьдарч, паалантай жорлонд бие засч байгаа. Өөрөөр хэлбэл, их болоод өндөр орлоготой айл өрх бүгд орон сууцанд орчихсон. Тэдний араас дундаас бага зэрэг өндөр орлоготой айл байранд амьдарч байна. Харин бага, дунд орлоготой иргэд бол гэр хороололд, байшинд, гэрт амьдарч, агаарыг бохирдуулах утаа, хөрсийг сүйдлэх угаадас, ялгадас "үйлдвэрлээд" байж байгаа. Тэд гэр хорооллоос салах дургүйдээ тэгээд байгаа юм биш. Орон сууц авна гэдэг үндсэндээ мөрөөдөл төдий болчихоод байгаа учраас л тэр. Өнөөдөр хамгийн хямд үнэтэй орон сууцны ам.метр нь 1.3 сая төгрөг байна. Гэхдээ бэлэн мөнгөөр нь худалдаж авахад л ийм боломж байгаа. ТОСК-ийн барьсан "Буянт-Ухаа" хорооллын байр гэхэд ам.метр нь 1350000 төгрөг байна. Хамгийн бага ам.метртэй байр нь л гэхэд 53 сая төгрөг. Залуу гэр бүлүүд, хуримтлалгүй өрх, орлого багатай айлд бол энэ тэнгэрт тулсан өндөр үнэ. Ядаж байхад төрөөс иргэдээ орон сууцжуулах олигтой бодлого барьж байгаа юм алга. Найман хувийн зээлийн хөтөлбөр хэрэгжүүлсэн гэдгийг мартаагүй, үгүйсгээгүй байна. Гэхдээ 30 хувийн урьдчилгаагаа бэлэн төлөөд, сардаа 300-400 мянган төгрөг төлчих орлоготой, мөнгөтэй айлууд нь аль хэдийнэ найман хувийн зээлд хамрагдчихсан. Тийм боломжтой айл мэр сэр байгаа л байх. Гэхдээ л бараг дуусч байна. Тиймдээ ч орон сууцны эрэлт эрс багассан. Эсрэгээрээ орон сууцны тоо нэмэгдэж, одоо зах зээл дээр 40-50 мянган айлын байр зарагдаагүй байж байна. Тэгсэн хэр нь л орон сууцны үнэ буурахгүй байсаар л. Албаны хүмүүс, судалгааны байгууллагаас орон сууцны үнэ буурч байна гэсэн мэдээлэл гаргаад байдаг. Яг ачир дээрээ буурч байгаа юм огт алга. Төрийн барьж байгаа орон сууцны үнэ ч гэсэн тийм ч бага биш байгаа. Уг нь бол ТОСК-ийн хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд барьж буй орон сууцны үнийг илүү бууруулж, ам.метрийг нь нэг сая төгрөгт ч багтаах боломж бий. Тэгэхийн тулд хорих төвд хүмүүжиж байгаа хүмүүжигчид, цэргийн алба хааж байгаа залуусаа ашиглая л даа. Үндсэндээ, тэднийг улс зүгээр л тэжээж байгаа шүү дээ. Тэгээд ч манай улсад 80 жилийн өмнөөс л барилгын цэргийн анги байгуулагдсан. Монголын цэргүүд үе, үеийн бүтээн байгуулалтын эзэд гэдэгтэй хэн ч маргахгүй. Нийслэл Улаанбаатар, Эрдэнэт хот, Дархан-Уул, Чойбалсан аймгаас эхлээд хөдөө нутгийн их бүтээн байгуулалтад гар бие оролцож бүтээлцэж байсан түүхийн эзэд бол тэд юм. Монголын барилгын салбарт онцгой үүрэг гүйцэтгэсэн том байгууллагын нэг нь барилгын цэрэг. Улс орны аж үйлдвэрийн бодлогыг хэрэгжүүлэхэд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Дорнод бүс нутагт аж үйлдвэрийн иж бүрэн парк-районыг барьж байгуулсан түүх ч бий. Тэгвэл одоо бид яагаад барилгын цэргийн ангийн алба хаагчдаар ямар нэг хэмжээгээр ашиглаж болохгүй гэж. Одоогоор Монгол Улсын хэмжээнд таван барилгын цэргийн анги байна. Тэнд алба хааж байгаа цэргүүд халагдахдаа барилгын мэргэжлийн үнэмлэхтэй болж байгаа. Тэднийг улсын чанартай бүтээн байгуулалтад ашигламаар байгаа юм. Цэрэгт намар татлаа, өвөл, хаврын хэдэн сар сургалаа. Зуны ид бүтээн байгуулалтын үед барилга дээр ажиллуулж, практик дадлага хийлгэхийн хажуугаар хямд ажиллах хүч болгон ашиглаж яагаад болохгүй гэж. Одоо ТОСК "Буянт-Ухаа-3"-ыг барина. Цаашлаад өөр төсөл, хөтөлбөрүүд ч хэрэгжүүлнэ. Тэгвэл тэр бүтээн байгуулалтуудаа цэргүүдээ ашиглая л даа. Ядаж л туслах ажлууд дээр нь. Цаашлаад мэргэжлийн хичээл заалгаж, суралцсан цэргүүд өрлөг, засал ч хийх боломжтой. Суурь, араг яс цутгах ажлыг ч хийж чадна. Ингэвэл барилгын гүйцэтгэлд зарцуулах мөнгө хамаагүй багасна. Цаашлаад барилгын хорих анги гэж байгуулсан ч яах вэ дээ. Байгуулах ч гэж дээ, нэг хорих ангиа барилгынх болгоод л гүйцэх. Цэрэг шиг ганцхан жилийн хугацаатай алба биш. Жирийн дэглэмтэй хорих ангид дунджаар авч үзвэл 3-5, цаашлаад 7, 8 жилийн ялтай хүмүүжигчид хүмүүжиж байгаа. Тэдэнд эхний нэг жилдээ барилгын бүхий л мэргэжлийн хичээлийг заагаад, сургаад, дадлагажуулаад авчихаж болно. Нэг жил багадана гэвэл 1.5 байя, хамаагүй. Тэгээд дараа нь барилга дээр ажиллуулаад, ял эдлэх хугацаанаас хасаж болж байна. Эсвэл цалингийн доод хэмжээгээр цалинжуулаад, данс руу нь хийгээд байсан ч болно. Хамгийн гол нь төрөөс хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөр дээр хямд ажиллах хүч ажиллуулбал цаашлаад өртөг нь буурна. ТОСК цаашлаад орон сууцны хороолол, хотхон барихдаа энэ мэт ажиллах хүчийг ашиглаад, байрныхаа ам метрийг сая, түүнээс багаар зарвал бага, дунд орлоготой иргэдэд хэрэгтэй. Дагаад Улаанбаатар хотын бүхий л бохирдлын асуудлыг ямар нэг байдлаар шийдэж, багасгаж болохоор байна.

Дугаарын 60 мэр

## Дарга нарын давралыг хуулиар хязгаарлаач

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Хаалгач, цэвэрлэгчээс нь авахуулаад хэлтэс, газрын дарга гээд бүгдийг нь солино. Өөрийн танил тал, хамаатан садан, найз нөхөд байвал мэдрэлийн өвчтэй ч байсан хамаагүй авчираад даргаар томилчихно доо. Оронд нь тухайн газартаа олон жил ажилласан, ур чадвар сайтай хүмүүсийг хууль бусаар халаад явуулчихна. Ихэнх нь өөр газар ажил хийгээд, эсвэл тоохгүй яваад өгдөг. Гэхдээ халагдсан болгон хүлцэнгүй байна гэж юу байх билээ. Шүүхдэнэ, заргалдана, тэмцэнэ. Заргалдсан хүмүүсийн цөөнгүй нь ялна. Ажилдаа эргэж орно. Ажилгүй байх хугацааны хохирлоо нэхэмжилнэ. Хамгийн гол нь тэр хохирлыг нь хууль бус шийдвэр гаргасан дарга биш төр барагдуулдаг буруу жишиг манайд байна. Тухайлбал, 2011-2015 оны хооронд шүүхээс хууль бусаар ажлаас халагдсан гэсэн 541 хэргийг шийдвэрлэж, 402 албан хаагч ажилгүй байсан хугацааны цалинд 4.21 тэрбум төгрөгийг гаргуулах шийдвэр гаргасан байна. Харин одоогоор 310 иргэн 3.8 тэрбум төгрөгийг улсын төсвөөс гаргасан. 400 гаруй сая төгрөгийн хохирлыг барагдуулаагүй байгаа аж. Ер нь бол хууль бусаар ажлаас халагдсан хүмүүсийн хохирлыг барагдуулах ажил хэвийн явагдаж байна гэж ойлгож болохоор. Гэхдээ хэн нэг дарга намын харьяалал, үзэмжээс үүдээд төрийн албан хаагчийг хууль бусаар ажлаас нь халсны хохирлыг төр, татвар төлөгчид барагдуулж байгаа нь өөрөө хэтэрхий гажуу хэрэг биш үү. Ер нь бол төрийн албан хаагчийн учруулсан хохирлыг төр барагдуулна гэх утгатай заалт Үндсэн хуульд байгаа. Дарга нар тэр заалтыг нь бариад л хуулийн цоорхойг ашиглаж, хэнийг ч хамаагүй үндэслэлгүйгээр ажлаас нь халж байна. Эргээд хохирлыг нь барагдуулахгүй, хувиасаа нэг ч төгрөг гаргахгүй болохоор тэр шүү дээ. Бүр нэг дарга томилогдож очоод, төрийн албан хаагчийг ажлаас нь халчихаж. Өнөөх нь гурван жил шүүхдэж явсаар байгаад ялж. Тэгэхээр нь шүүхийн шийдвэрийг биелүүлээд ажилд нь эргүүлж авчихаад, гурав хоногийн дараа буцаагаад халчихсан байх жишээтэй. Энэ хугацаанд гарсан 100 сая төгрөгийн хохирлыг төр барагдуулсан. Дарга бол зүгээр л тухайн ажилтныг янаглан хорлож, хөөрхөн тоглочихоод, зугаагаа гаргасны төлөө гарсан хохирлыг төрөөр төлүүлчихээд л сууж байна. Ийм байж болох уу даа. Ингэхээр төрийн алба баталгаагүй, дарга үзэмжээрээ албан хаагчдыг халдаг байдал яаж алга болох юм. Тийм болохоор Төрийн албаны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах цаг болсон. Ядаж л хууль бусаар төрийн албан хаагчийг дураараа халсан дарга хохирлыг нь хувиараа барагдуулдаг заалтыг хуульд оруулж өгмөөр байна. Тэгэхгүй бол дарга сэтэртэй бухэн даварч гүйцлээ.

ТОМИЛОЛТ

# МАН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Амарбаясгалан "Намын ажилтны бүсийн зөвлөгөөн"-д оролцлоо











МАН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Амарбаясгалан хөдөө орон нутгийн иргэдийнхээ санаа бодлыг сонсох, МАН-ын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар мэдээлэл хэрхэн хүрч буйг судлах, тухайн орон нутагт тулгамдаж буй зарим асуудлыг шийдвэрлэх зорилгоор ажлын хэсэг бүрдүүлж, ахлан 21 аймгаар тойрон ажиллаж байгаа билээ. Энэ томилолтын хүрээнд 16 аймагт ажиллаж, иргэдтэй уулзалт зохион байгуулаад байна. Тэгвэл энэ сарын 08-наас орон нутаг дахь намын ажилтнууд, удирдлагуудыг идэвхжүүлэх, хариуцлагын тогтолцоог сайжруулах, намын дотоод эв нэгдлийг бэхжүүлэх зорилготой "Эв нэгдэл, Хариуцлага, Ялалт" уриан дор "Намын ажилтны улсын зөвлөгөөн"-ийг улс орон даяар зохион байгуулахаар болж, говийн бүсийн зөвлөгөөнийг Өмнөговь аймагт хийж эхлүүллээ. Намын ажилтны улсын зөвлөгөөн энэ сарын 30 хүртэл таван бүс, нийслэлийн долоон дүүрэгт зохион байгуулагдах юм. Өмнөговь аймгийн Даланзадгадад болсон "Намын ажилтны улсын зөвлөгөөн"-д Говьсүмбэр, Дорноговь, Дундговь болон Өмнөговь аймгийн намын ажилтнууд хамрагдсан бөгөөд зөвлөгөөний хүрээнд намын хороодын дарга, удирдлагуудын салбар хуралдаан, дэд дарга, улс төрийн ажилтнуудын салбар хуралдааныг зохион байгуулав. Намын ажилтны улсын зөвлөгөөний нээлтэд МАН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Амарбаясгалангаас гадна УИХ-ын гишүүн, НАМЭХ-ийн Ерөнхийлөгч Ц.Цогзолмаа, УИХ-ын гишүүн Л.Энхболд, УИХ-ын гишүүн Н.Амарзаяа болон МАН-ын Улс төр, намын байгуулалтын газрын дарга Б.Баярбаатар, МАН-ын Нийгэм, эдийн засгийн хөгжлийн газрын дарга Д.Өнөрболор, МАН-ын Ерөнхий нарийн бичгийн даргын зөвлөх Л.Цэнгүүнжав, МАН-ын Хяналтын Ерөнхий хорооны дарга Х.Болдмандал, МАН-ын дэргэдэх Ахмадын холбооны тэргүүн, МАН-ын Удирдах зөвлөлийн гишүүн С.Төмөр-Очир нар оролцлоо. Энэ үеэр МАН-ын дарга, УИХ-ын дарга М.Энхболд зөвлөгөөнд амжилт хүсч, мэндчилгээ ирүүлснийг МАН-ын Улс төр, намын байгуулалтын газрын дарга Б.Баярбаатар уншиж танилцуулсан юм. Д.Амарбаясгалан "Намын ажилтны улсын зөвлөгөөн"-ийг нээж хэлсэн үгэндээ "Намынхаа ачааны хүндийг үүрч ажлын голыг нугалж, халуунд нь халж хүйтэнд нь даарч, ялсан үед яллаа гэж ач тус нэхдэггүй, ялагдсан үед нь сэтгэлээр унаж ажлаа хаяад зугтдаггүй, үнэнхүү хоёргүй сэтгэлээр бүхий л хүч чадлаа намынхаа төлөө зориулдаг та нар шиг олон мянган намын гишүүн байдаг нь энэ намыг амжилтад, ялалтад хүргэж, хөтөлж явдаг билээ. Та бүхэнтэйгээ нүүр тулан уулзаж, сэтгэлийн үгийг тань сонсож, туулсан замаа дүгнэж, цаашид ажиллах зорилго чиглэл, арга технологио ярилцан, бүтэхгүй саад тотгорыг арилгаж, ажлын шинэ арга барил, сайн туршлага бүхнийг дэлгэрүүлэх зорилгоор бүсчилсэн зөвлөгөөнийг зохион байгуулж байна. Зөвлөгөөнийг зургаан газар бүсчлэн зохион байгуулж байгаа" хэмээн онцолсон юм. "Намын ажилтны улсын зөвлөгөөн"-д оролцогчид зөвлөгөөнөөсөө эв нэгдлийг эрхэмлэн, үүрэг хариуцлагаа өндөржүүлэн, ялалтын буухиаг үргэлжлүүлэхийн төлөө дор бүрнээ хичээн ажиллахыг нийт гишүүд дэмжигчиддээ хандан уриаллаа. Түүнчлэн МАН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга орон нутагт ажиллах томилолтынхоо ажлыг давхар амжуулж, Өмнөговь аймгийн иргэд, хөдөлмөрчидтэй уулзаж, тус аймгийнхны өмнө тулгамдаж буй асуудлуудтай танилцахын зэрэгцээ цөөнгүй асуудлуудыг ажлыг хэсгийхнээр шийдүүлсэн юм. Тодруулбал, БСШУС-ын дэд сайд Ё.Отгонбаяр Номгон сумын соёлын төвийг засварлах 488 сая төгрөгийг шийдсэн. ХЗДХ-ийн дэд сайд аймгийн хууль хүчний байгууллагад найман автомашин, 140 холбооны хэрэгсэл хуваарилсныг мэдээлж, 14 айлын орон сууцыг энэ оны III улиралд ашиглалтад оруулна гэж амлав. Мөн Хилийн тухай хуулиар ажиллагсдын цалингийн 25 хувьтай тэнцэх урамшууллыг таван жилд нэг удаа олгодог болсныг дуулгасан юм. Түүнчлэн тус аймгийн эрүүл мэндийн байгууллагуудадтаванавтомашин хуваарилснаа салбарын дэд сайд Л.Бямбасүрэн мэдээлсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд Д.Загджав тус салбарт гадаадын хөрөнгө оруулалтын 64 хувь нь хийгдэж, ДНБ-ий 18 хувь, улсын төсвийн орлогын дөрөвний нэгийг бүрдүүлж байгаа талаар мэдээлсэн. Тус уулзалтад УИХ-ын гишүүд, түүний дотор уг тойргоос сонгогдсон гишүүн Н.Амарзаяа, Л.Энхболд нар оролцож, УИХ-аас батлан гаргасан хууль, тогтоомжийн талаар дэлгэрэнгүй тайлбар өгч, тойрогтоо хийсэн, хийхээр зэхэж буй ажлын тухай мэдээлсэн юм. Иргэдтэй хийсэн уулзалт, тэнд хуран цугласан хүмүүсээс харахад Монголчууд хувийн гэхээсээ илүүтэй улс орны хөгжил, эдийн засаг, боловсрол, соёлын асуудалд санаа тавьдаг болж буй нь харагдаж байлаа. МАН-ын ажилтны улсын зөвлөгөөн цааш зүүн, төв, хангай, баруун бүсэд зохион байгуулагдах бол Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Амарбаясгалангийн орон нутагт ажиллах томилолт Дархан, Сэлэнгэ аймгуудаар үргэлжилнэ.

ЦАГ ҮЕ

# Б.ХУРЦ ХУУЛИЙНХНЫГ ХУУР







Хэрэв түүх сөхвөл, Хятадын тагнуулын алба XX зууны эхнээс Монгол Улсыг тасралтгүй тагнасаар эдүгээ хүрлээ. Өнгөрсөн зууны эхээр "Гурамсал", "Цагаан сараана", "Газар тэнгэр", "Ах дүүс", "Гэзэггүйчүүд" гэх мэт тагнуулын олон бүлгийг үүсгэн байгуулж, монголчуудыг тагнаж хагарган бутаргаж ирсэн байдаг. Эдгээр бүлгийн дотроос хамгийн олон гишүүнчлэлтэй тагнан турших хорлон сүйтгэх бүлэг бол "гурамсал". Хятад худалдаачид "гурамсал"-ын гол цөм болж ажилладаг байсан юм. Олноо өргөгдсөн Монгол Улсын үед 100 мянган хятад худалдаачин Монгол орноор хэрэн хэсч явдаг байжээ. Тэдний олонхи Хятадын тагнуулын мэдээллийн нууц эх сурвалж болдог байсан. Хятадын нийгэм, улс төрийн үзэгдэл, үйл явцын өөрчлөлт, хувиралтыг дагаад тагнуулын нууц бүлгүүдийн нэр хаяг нь ч солигдож ирсэн. Ардын засгийн жилүүдэд манай улсын эсрэг "Урам зориг хөгжүүлэх нийгэмлэг", "Их Азийн бүлэг" гэх зэрэг Японы тагнуулын халхавчийн байгууллагуудын нэр хаягийг зээлдэн Хятадын тагнуулууд БНМАУ-ыг тагнах ажиллагаа явуулдаг байв. БНХАУ 1949 онд байгуулагдсаны дараагаар манай нам, засаг 1954 оны эцсээр улсын хилийг найрамдал нөхөрлөл, эв нэгдлийн хил болгон зарлаж, Цэргийн яам, Дотоод яамыг 90 гаруй хувиар цомхотгон нэгтгэж, хилийн цэрэг, хилийн хамгаалалтыг татан буулгасныг далимдуулан энэ зай сиймхийгээр 50-иад онд Хятадын тагнуул туршуулууд олон арваараа манай нутагт чөлөөтэй шургалан орж тархан суурьшдаг болсон юм. 50-иад он, 60 оны эхээр манай улсын баруун хилээр Хятадын цэрэг, тагнуулын салбар цөмрөн орж ирж, нутгийн ард иргэдийг хөөн зайлуулж, газар нутгийг эзлэн сууж, шаардлага тавьсан аюулаас хамгаалах, хилийн төлөөлөгчдийг баривчлан зоддог хэрэг явдлыг удаа дараа гаргаж, хил орчмын нөхцөл байдлыг хурцатгаж байсан. Хятадуудтай харилцан зодолдвол түүгээр шалтаглан цэргийн мөргөлдөөн, хэрэг будлиан үүсгэхэд бэлэн байсан бөгөөд тийм шалтаг олгохгүйн тулд манай аюулаас хамгаалах, тагнуул, хилийн төлөөлөгчид номхон хүлцэнгүй байж, Хятадын цэрэг цагдаа тагнуулынхны зодуурыг тэсвэрлэхээс өөр аргагүйд хүрдэг байв. Хятадуудад зодуулснаас манай аюулаас хамгаалах, хилийн төлөөлөгчдийн олон арван офицер, ахлагч, ажилтнууд гэмтэж бэртжээ. Баруун хилд цөмрөн орж ирсэн Хятадын цэргийн тагнуулын салбар манай нутаг дээр тагнуулын үйл ажиллагаа явуулж эхэлсэн юм. 1960, 1961 оны байдлаар Монголын нутагт тагнах ажиллагаа явуулах үүрэг бүхий 100 туршуулаас бүрдсэн маш нууц сүлжээ байгуулчихсан нь илрэв. БНМАУ-ын Засгийн газар Хятадын коммунист намын тэр үеийн эрх баригчдын дотоод зөрчил тэмцэл туйлдаа хүрснийг харгалзан үзэж, мөн социалист Хятад улсын нэр хүндийг дэлхий дахинаа унагахгүй байх үүднээс энэ тагнуул туршуулын асуудлыг олон нийтэд зарлан мэдээлэхгүйгээр чимээгүйхэн өнгөрч, харин тэднийг гүйцэтгэх ажлын шугамаар нутаг орноосоо хөөн зайлуулаад орхисон байдаг. Хоёр орны харилцаа үндсэндээ хаалттай байсан 1960-аад оны эцэс 70, 80 онуудад "тэрс үзэлтэн", "соёлын хувьсгалд өртөгсөд", "чөлөөт амьдрал эрэгчид", "улс төрийн оргодол" гэх мэт нэр хаягаар тагнуул туршуулаа Монгол Улсад нэвтрүүлдэг байсан. Түүнээс гадна 60-аад онд Улаанбаатар хот дахь хятад иргэдийн зөвлөл, хятад арван жилийн сургууль, хятад эмнэлэг, хятад ажилчдын клуб зэрэг байгууллагууд Монголыг тагнан турших, Мао Зэдуны үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, соёлын хувьсгалыг Монголд өрнүүлэх үйл ажиллагаа явуулах бааз суурь түшиц газар болж хувирсан. Мөн Улаанбаатар дахь хятад иргэдийн үүсгэн байгуулсан хувийн жижиг үйлдвэр, засварын газар, дэлгүүр мухлаг гуанз, ахуй үйлчилгээний цэг салбарууд зарим тохиолдолд Хятадын тагнуулын ажиллагааг ивээн тэтгэх, хаацайлан хамгаалах үүрэг биелүүлдэг болсон билээ.

Хятадын тагнуулын байгууллагын Монгол орныг тагнасан хэрэг явдлыг зэрвэсхэн гүйлгэж харвал өнгөрсөн XX зуун бол өмнөдийн Монгол Улсын эсрэг явуулсан нууц тэмцлийн он жилүүд байсан болно. Энэ тэмцлийн гол зорилго тагнуулын аргаар Монголыг эзлэх явдал байсныг баримтууд харуулдаг. XX зууны төгсгөл 1990-ээд оноос "Хятадын олон улсын соёлын солилцооны төв", мөн пүүс компани бизнес, хувийн хэргээр зорчигчид зэрэг халхавчаар Хятадын тагнуулчид Монгол Улсыг тагнан турших, түүгээр үл барам Монголын төрийн бодлогод нөлөөлөх зорилгоор манай зарим иргэнийг элсүүлж, монголчууд биднийг хэтэрхий басамжлах болсон юм. Үүний нэг тодорхой баримт бол Хятадын тагнуулчид Соёлын төвийн халхавчаар Ц.Нямдоржийг Хятадын тагнуулд элсүүлсэн ажиллагаа болно. Ц.Нямдоржоор дамжуулан Монголын улс төрд нөлөөлөх, Монголын нийгэм улс төр, эдийн засгийн асуудлаар мэдээ олж авах зорилт тавьж энэ санаархлаа ч тэд биелүүлж чадсан. Энэ бол Монгол Улсын аюулгүй байдал, ард түмний эрх ашигт шууд халдсан асуудал. Монгол Улсын эсрэг чиглэсэн Хятадын тагнуулчдын маш нууцлагдсан ажиллагаануудын нэг болох Ц.Нямдоржийн Хятадын тагнуулын гар хөл болсон асуудлыг шалгаж өгөхийг хүсч, төр засгийн дээд байгууллагад удаа дараа хандаж ирсэн билээ. Энэ асуудлыг дахин нягтлан шалгаж өгөхийг хүсч 2016 оны арванхоёрдугаар сард Монгол Улсын прокурорын байгууллагад хандаж өргөдөл гаргасан юм.

Прокурорын байгууллага миний өргөдлийг хүлээн авч шалгуулахаар Тагнуулын ерөнхий газарт шилжүүлжээ. Гэтэл дарга Б.Хурц нутаг ус нэг, энэ тэрийг бодоод энэ асуудлыг шалгахгүй цааргалж байгаа бололтой. Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд хор хохиролтой Нямдоржийн Хятадын туршуултай холбоо бүхий асуудлыг шалгахад айж болгоомжлоод байх явдалгүй баймаарсан. Тагнуулын ерөнхий газрын үндсэн чиг үүргийн нэг бол харийн тагнуул туршуултай тэмцэх явдал. Хятадын туршуул Ц.Нямдоржийг шалгахгүй удаашруулаад байгаа тул олон нийтэд хандаж, түүнийг Хятадын тагнуулчид хэрхэн элсүүлсэн бодит үнэнийг ард түмэнд хүргэе гэж бодсон юм. Учир юу вэ гэвээс энэ нь Монголын тусгаар тогтнол, аюулгүй байдал, ард түмний хувь заяатай салшгүй холбоотой асуудал байгаа юм. Тиймээс Монголын ард түмэн үнэнийг мэдэх ёстой, тийм ч эрхтэй.

Ц.Нямдорж 1990 оны 05 дугаар сард Хятадын тагнуулын хүмүүстэй холбоо тогтоосон тухай мэдээллийг тэр үеийн аюулгүй байдлыг хангах байгууллагын ажилтнууд тус тусынхаа шугамаар авч байсан юм билээ. Үүнийг батлах нэг баримт бол Соёлын төвөөр халхавчилсан Хятадын тагнуулын хүмүүстэй Бээжинд 1990 оны 05 дугаар сард очиж уулзсан тухай үйл явдлыг харуулсан өнгөт гэрэл зургууд байдаг юм. 80-аад оны сүүлчээр Бээжингээс Улаанбаатар хотод ирж, орос хэлний сургалтад хамрагдсан нэгэн хятад залуу Нямдоржтой танилцсан байдаг. Энэ хятад залуу Нямдоржийг хятадад аваачих ажлыг зохион байгуулсаныг тэр үеийн Аюулаас хамгаалах байгууллагын ажилтан гэрчлэн ярьдаг юм. Тэгэхээр Ц.Нямдорж 1990 оны 05 дугаар сард Бээжинд очиж Соёлын төв нэрийн дор ажилладаг хятадын тагнуулын хүмүүстэй харилцаа тогтоосон нь тодорхой байгаа юм.

Хятадын тагнуулын албаныхан Ц.Нямдоржийг өөрийн тагнуулд элсүүлэх зорилгоор 1990, 1991 онд судлах ажлыг гүнзгийрүүлж түүнийг дахин Бээжинд очуулах ажлыг санаачлан зохион байгуулжээ. Хятадын тагнуулчид түүнийг нууцаар Бээжинд аваачиж элсүүлэх зорилт тавьсан нь тэдний ажиллагааны арга барилаас маш тодорхой харагддаг. Хятадын тагнуулын харьяа халхавчийн байгууллага-соёлын төвийн ажилтан Ян Жухуа удаа дараа Улаанбаатарт томилолтоор ирж, Ц.Нямдорж, түүний орчин тойрныг тагнан судалж улмаар Ц.Нямдоржийн Бээжин явах нөхцөлийг бүрдүүлсэн байдаг. Ян Жухуа 1992 оны эхээр Нямдоржийг дагуулан Бээжин явсан юм.

Ц.Нямдорж Соёлын төвийн нууц урилга, төсөв зардлаар Бээжинд хүрэлцэн очиход соёлын төвийн нэр хаягаар халхавчилсан хятадын тагнуулын ажилтнууд угтан авч зочид буудалд байрлуулан үйлчилсэн. Хятадын тагнуулын байгууллагын үйл ажиллагаа өөрийн гэсэн өвөрмөц онцлог, тодорхой шинж тэмдэг арга барилтай байдаг юм. Энэ шинж тэмдгээрээ Соёлын төвийн ажилтнуудын үйл хөдлөл үг яриа бүр хятадын тагнуулын ажиллагаа болох нь бүр тодорхой болсон юм. Соёлын төвийн гэх ажилтнууд Нямдоржтой шууд л тагнуулын арга барилаар ажиллаж эхэлсэн. Ц.Нямдоржтой тогтоосон харилцааг маш нууцалж, уулзалт бүрийн нууцлалыг хамгаалахад ихээхэн анхаарсан. Нууцлалыг хатуу сахихыг Ц.Нямдоржид байнга анхааруулж байсан.

Ц.Нямдоржийг дагалдаж явсан хүмүүсээс нь салгаж ганцаарчлан уулзаж бүх яриаг түүний саналаар орос хэлээр явуулсан. Хятадын тагнуулынхан Ц.Нямдоржийг тагнуулын ажилд татан оролцуулж, ямар ч тохиолдолд нууцаар хамтран ажиллахаас татгалзахгүй байх нөхцөлийг бүрдүүлж чадсан. Энэ зорилгоор Ц.Нямдоржийг Бээжингийн хамгийн тансаг зэрэглэлийн зочид буудалд байрлуулж архиар согтоож ялагдас бөөлжистэй нь хутгаж сэтгэл зүйн гүн дарамт үзүүлсэн. Өндөр үнэтэй зочид буудалд байрлуулж ихээхэн зардал гаргасан, мөнгө төгрөг бэлэг сэлт өгснөө Ц.Нямдоржид байнга сануулсаар байсан. Тэд Ц.Нямдоржид үйлчлэх хугацаандаа түүнтэй ярилцаж Монголын улс төр, нийгэм, эдийн засгийн асуудлаар тодорхой мэдээ олж авсан.

Монгол, Хятадын олон жил хаалттай байсан харилцаа 1992 оны эхээр сэргэх хандлагатай болж байсан учраас Монголын тухай мэдээлэл хятадын тагнуулчдад нэн чухал хэрэгтэй болсон юм. Хоёр орны худалдаа эдийн засгийн харилцаа, хувийн аялал жуулчлал идэвхжсэнтэй холбогдуулан Хятадын тагнуулын алба Монгол Улсын талаар тагнах судлах ажлыг өмнөх үеэс эрс өргөжүүлэх сонирхолтой болсон цаг үе байлаа. Монгол, хятад хоёр орны харилцаа нээлттэй болсноор хятадын тагнуулчид монголд чөлөөтэй ажиллах аятайхан нөхцөл боломж ч гарсан. Ийм агшин хоромыг алдахгүйн тулд хятадын улс төрийн тагнуулчид Монголын засаг, төрийн байгууллагад мэдээллийн эх сурвалжтай болохыг ихэд яарч чармайж эхэлсэн.

Хятадын тагнуулчид монголчуудын дотроос элсүүлэх тагнуул туршуулд тавьдаг нэг гол шалгуур бол аль ч тохиолдолд олон нийтийн итгэл найдварыг хүлээж чадах тухайн хувь хүний чадвар, албан тушаал аажмаар ахиж дэвших боломжийг нь онцгойлон авч үздэг юм. Хувийн шинж чанараараа тийм эх сурвалж-туршуул болгож болох хүнд Ц.Нямдоржийг оруулсан байдаг. Соёлын төвийн халхавчаар ажилладаг хятадын тагнуулчид Ц.Нямдоржийн бүх яриаг нууц камераар бичлэг хийж баримтжуулсан. Ц.Нямдоржийн үг яриа, үйлдэл хөдөлгөөнийг баримтжуулснаараа түүнийг тагнуулынхаа урхинд гүн оруулсан юм. Хамгийн гол нь түүнийг нууц туршуулаар элсүүлэх зорилгодоо хүрсэн.

Ц.Нямдоржтой ажиллаж байсан хугацаандаа Соёлын төвийн ажилтнууд үг яриа, үйл хөдлөл, байр байдлаараа өөрсдийгөө тагнуулын ажилтнууд болохоо бүрэн харуулсан. Соёлын төвийн төлөвлөлт зохицуулалтын газрын захирал Лю Шианминь гэгч эмэгтэй уулзалт бүр дээр Ц.Нямдоржийн ярьсан зүйлийг тэмдэглэж байсны зэрэгцээ нууцаар техникийн бичлэг давхар хийсэн. Соёлын төвийн халхавчаар ажилладаг тагнуулчид Анчаунбу-гийн \ тагнуулын\ шугамаар элсүүлэхэд саад бэрхшээлгүй боллоо гэж өөр хоорондоо шивнэлдэж байсан гэдэг. Хятадын тагнуулын газрын халхавчийн байгууллага болох Соёлын төвийн ажилтнууд Ц.Нямдоржтой удаа дараа уулзаж сорьж шалгасны дараа элсүүлэх ажлыг шуурхайлан зохион байгуулсан.

Хятадын тагнуулын албаны халхавчаар ажилладаг Соёлын төвийн нарийн бичгийн дарга тэргүүн профессор Мао Гуохуа Ц.Нямдоржийг элсүүлэх ажлыг биечлэн явуулсан. Тэрээр Ц.Нямдоржтой уулзаж түүний түүх намтарыг дэлгэрэнгүй байдлаар асууж ярилцсан. Тухайлбал, Ц.Нямдоржийн хаана ямар ажил албан тушаал эрхэлж байсан, хэдэн жил ажилласан, хэдэн настай, гэр бүлийн байдал, ам бүл, хувийн машин, байшинтай эсэх гэх зэргээр асууж түүний амьдрал ахуйтай нарийвчлан танилцсан. Энэ нь хятадын тагнуулын шугамаар өмнө нь судалж цугларуулсан Ц.Нямдоржийн түүх намтартай холбоо бүхий мэдээлэлтэй хэр тохирч буй, Ц.Нямдорж хэр үнэн ярьж байгааг шалгадаг хятадын тагнуулын байгууллагын элсүүлэх ажиллагааны эхний шатны арга ажиллагаа болно.

Мао Гуохуа элсүүлэх ажиллагааны дараахь шатад аажмаар шилжиж, Ц.Нямдоржийг ашиглан Монголын улс төр, нийгэм, эдийн засгийн холбогдолтой үйл явцад нөлөөлөхөд түүний албан тушаал эрх мэдэл, бодит боломж хэр байгааг тодруулах замаар түүнтэй ярилцлага хийсэн. Тухайлбал Монгол улсын улс төрийн нөхцөл байдал, намуудын тогтолцоо, тэдгээрийн үзэл баримтлал, хэтийн төлөв байдал, сонгуулийн хууль, 1992 оны УИХ-ын сонгуульд аль нам ялах магадлалтай зэрэг асуудлаар ярилцаж Нямдоржийн улс төрийн байр суурийг тодруулсан. Мөн Эрдэнэтийн үйлдвэр, төмрийн хүдрийн орд газар зэрэг үйлдвэр, ашигт малтмалын чиглэлээр ярилцаж, хятад монголын эдийн засгийн хамтын ажиллагааг хятадад ашигтай байлгахад хэр нөлөө үзүүлж чадахыг тодруулсан.

Улс төр, эдийн засаг, худалдаа, ялангуяа Эрдэнэтийн зэсийн баяжмалыг хятадад гаргах асуудлаар Засгийн газрынхаа бодлого, үйл ажиллагаанд нөлөөлж чадна биз дээ гэж хэдэнтээ Ц.Нямдоржоос асууж лавлан, чадна гэсэн амлалтыг түүгээр хэлүүлсэн байдаг. Ц.Нямдорж тэр үеийн Хууль зүйн тэргүүн дэд сайдынхаа хувьд Засгийн газраар дамжин Улсын бага хуралд өргөн баригдах хуулийн төслийг боловсруулахад шууд оролцдог байсан нь хятадын тагнуулын байгууллагын анхаарлыг гойд ихээр татсан байдаг. Нямдорж УИХ-аар баталсан хуулиудыг ёсчлохын өмнө дур мэдэн засвар оруулаад их хурлын даргын албан тушаалаас огцорсон шүү дээ. Мао Гуохуагийн Ц.Нямдоржийг элсүүлсэн ажиллагаа орос хэлний орчуулгатай нэг цаг үргэлжилсэн. Мао Гуохуа Ц.Нямдоржтой ярилцсан ярианыхаа явцад түүнийг тагнуулын ажилд ашиглахад боломжтой гэсэн дүгнэлт хийж элсүүлэх ажиллагааг цаашид улам батлагаажуулсан нь дараагийн үйл ажиллагаанаас харагддаг.

Соёлын төвийн шинжлэх ухаан технологийн газрын захирал Тунь Шаобин элсүүлэх ажиллагаа явуулсны дараа түүнд ихээхэн итгэл хүндэтгэл үзүүлж, Нямдоржийг дагуулан Соёлын төв гэсэн хаягтай 5 давхар байранд оруулж, өрөө тасалгааныхаа байдалтай танилцуулж цай өгсөн. Яриа орос хэлээр явагдсан. Ц.Нямдоржийг элсүүлсэн ажиллагааг нууцалж булзааруулахын тулд зориуд халхавчийн байгууллага-соёлын төвөөр оруулж гаргасан нь энэ юм.

Ц.Нямдоржийг элсүүлсэн ажиллагааг үргэлжлүүлэн баталгаажуулсан уулзалтыг хэд хэдэн удаа зохион байгуулсан байдаг. Засгийн газрын ажилтан гэх Пан Сун Нямдоржтой уулзаж, хоёр цаг гаруй ярилцсан. Тэрээр хятад, монголын харилцаа хамтын ажиллагаа, монгол орны улс төрийн нөхцөл байдал, намуудын үйл ажиллагаа уялдаа холбоо зэрэг асуудлаар ярилцсан. Пан Сун Нямдоржтой ярилцсан зүйлээ түүнийг дагалдан яваа хүмүүст мэдүүлэхгүйн тулд яриаг орос хэлний орчуулагчтай явуулсан, харин өөрөө Саньши аялгаар зориуд яриад байсан. Саньши аялгаар ярьсаныг тэр уулзалтад оролцсон хятадын тагнуулын ажилтны зарим нь ч ойлгохгүй байсан. Пан Сун Ц.Нямдоржид аятайхан сэтгэгдэл төрүүлж түүнтэй тогтоосон харилцаагаа улам лавшруулах зорилгоор Ц.Нямдоржийг Тянь Жин хотоор зугаалуулах үүргийг Тунь Шаобин гэдэг эмэгтэйд өгсөн. Тунь Шаобин Нямдоржийг дагуулан Тянь Жин хотын дарга удирдлагатай уулзуулж, түүнд бүх талаар үйлчилсэн. Тянь Жин хотын дарга Ц.Нямдоржид баярлаж талархсанаа илэрхийлж бэлэг сэлт өгсөн.

Тянь Жингээс Бээжинд буцаж ирсний дараа Соёлын төвийн ерөнхий нарийн бичгийн дарга тэргүүлэх инженер Ли Жиашиан Ц.Нямдоржийг хүлээн авч уулзжээ. Энэ уулзалданд хятадын тагнуулын ажилтан Тунь Шаобин, Ян Жухуа оролцжээ. Яриаг орос хэл дээр явуулсан. Ли Жиашиан Ц.Нямдоржтой дахин уулзахаар тохирсон. Нямдорж хятадын тагнуулын ажилтнуудын туслалцаа дэмжлэгтэйгээр монголын тагнуулын хяналтаас зориуд санаатай зугтаж, зам мөрөө буруулан хоёр өдөр дараалан хагас өдрөөр алга болсон. Энэ алга болсон хугацаанд Нямдорж хаана хэнтэй уулзаж юун тухай ярьснаа тайлбарлах учиртай.

Мао Гуохуа, Цао Дапинь хоёр тус тусдаа 3 удаа Ц.Нямдоржтой уулзаж, орос хэлний орчуулагчаар дамжуулан ярилцсан байдаг. Мөн 1990 оны 5-р сард Бээжинд очсон, 1992 онд Бээжин хотын буудалд орой бүр нэг хятадтай уулзаж ярилцдаг байсан, хятадын тагнуулчид Улаанбаатар луу үдэж гаргахын өмнө галт тэрэгний буудалд Ц.Нямдоржид гардуулан өгсөн том шар дугдуйн дотор юу байсан зэрэг асуудлаар тэрээр тайлан бичиж өгөхөөс зайлсхийсээр ирсэн. Ц.Нямдорж тайлганах үүрэггүй байсан гэдгээ хожим 2003 онд хэвлэл мэдээллээр удаа дараалан мэдэгдсэн. Хууль Зүйн сайд Ж.Амарсанаагийн тушаалаар Бээжинд 1992 оны эхээр болсон олон улсын хуульчдын бизнес уулзалтад оролцсон гэсэн бичиг хийлгэж, архивын бичиг баримтад хавсаргаж хятадын тагнуултай холбогдсон хэрэг явдлаа булзааруулсан байна билээ.

Хууль зүйн яамны шугамаар Бээжинд бизнес уулзалтад оролцсон бол мөн тайлагнах ёстой. Гэтэл тайлан байдаггүй юм. Бас Бээжинд томилолтоор хуульчдын бизнес уулзалтад оролцсон бол төсөв зардлыг Хууль зүйн яам гаргасан байх ёстой. Санхүүгийн ийм баримт байдаггүй юм. Хятадын тагнуулын албаны хүмүүсийн өгсөн бэлэг дурсгалын зүйлийг тэр үед үйлчилж байсан Засгийн газрын тогтоолын дагуу үнэлүүлж авдаг журмыг зөрчсөн. Сайд, дэд сайд, тусгай газрын дарга өөр улс оронд явах бол засгийн газрын хуралдаанаар орж шийдвэр гаргасны дараа явдаг журамтай



Реклам, зар сурталчилгааны алба: **99173710**

# РСААР БАЙХ УУ

байсан. Хуулийг үргэлж дагаж мөрддөг гэж ярих дуртай Ц.Нямдорж энэхүү журмыг сайн мэдэж байсан.

Хятадын тагнуулын ажилтнууд Ц.Нямдоржийг элсүүлж, олон дахин уулзаж, харилцаа холбоогоо бататгасны дараа түүнтэй хамтарч ажиллах арга зам, холбоо барих, нууцлал хадгалж хамгаалах талаар зааварчилга өгсөн байдаг. Жишээлбэл тагнуулын ажилтан Тунь Шаобин Бээжинд бидэнтэй уулзсан тухайгаа нутагтаа очоод хэн нэгэнд хэлж огт болохгүй. Бидэнтэй утсаар ярьж болохгүй. Зөвхөн Ян Жухуагаар дамжуулан захидал бичиж, өөрийнхөө байдлыг мэдэгдэж байхыг Ц.Нямдоржид зааварлаж, хятадын тагнуулын байгууллагатай тогтоосон харилцаа холбоогоо нууцалж байхыг дахин дахин сануулсан байдаг. Ц.Нямдорж Туньгийн зааврыг даган биеүүлж ирсэн юм. Соёлын төвийн нарийн бичгийн дарга, профессор Цао Дапинь Улаанбаатарт суугаа Хятадын элчин сайдын яамны соёлын атташе Жао Вэньжунд 1992 оны 2-р сарын 10-ны өдөр захидал бичиж, Ц.Нямдоржтой уулзаж холбоотой ажиллахын зэрэгцээ түүний байр байдлыг төвд \Бээжинд\ мэдэгдэж байхыг даалгасан байдаг.

Цао Дапинь энэ харилцаа нэн чухал гүүр болох юм шүү гэдгийг Жао Вэньжунд анхааруулсан. Чамайг Бээжинд ирсэний дараа Нямдоржийн талаар дэлгэрэнгүй ярья гэж захидалдаа бичсэн байсан. Энэ нь хятадын тагнуулын арга ажиллагаа гэдгийг мэргэжлийн бус хүнд ч ойлгомжтой байгаа юм. Соёлын төвийн дээрх нэр бүхий ажилтнууд Ц.Нямдоржтой соёлын асуудлаар нэг үг ч яриагүй байдаг юм. Ингэснээрээ тэд тагнуулын зорилгоор Ц.Нямдоржийг урьж Бээжинд аваачин түүнийг элсүүлсэн болохоо бүрэн харуулж өөрсдийгөө илчилж өгсөн. Тунь Шаобин нутагтаа очсоны дараа Ц.Нямдорж хятадын тагнуулын байгууллагад элсэгдсэнээ задалж буй эсэхийг шалгуулахаар өөрийн удирдлагад байдаг Ян Жухуаг удаа дараа томилж, Улаанбаатарт ажиллуулсан байдаг. Тэрээр Ц.Нямдоржийг шалгаж сэтгэл санаа ажил төрөл нь хэр байгааг судалж сэжигтэй зүйл илрүүлээгүй аж. Тиймээс хятадын тагнуулын байгууллага өөрийн хоёр тагнуулчныг томилон Ц.Нямдоржтой уулзуулж дахин заавар чиглэл өгүүлэхээр Улаанбаатар луу явуулсан юм.

Хятадын тагнуулын ажилтан Сун Хаовэй, Хун Тианюй гэгч хоёр хүн Ц.Нямдоржтой сэм уулзахаар Бээжингээс Улаанбаатарт онгоцоор 1992 оны 10-р сард ирсэн. Тэд мөн сарын 26-ны өдөр Улаанбаатар зочид буудалд Ц.Нямдоржтой уулзсан. Хятадын тагнуулын ажилтан энэ хоёр хүн Ц.Нямдоржийн байр байдлыг шалгах, түүнтэй ярилцаж Монгол улсын улс төр, эдийн засгийн бодлого цаашдын чиглэл, АНУ, Япон, Солонгос улсуудтай тогтоосон хамтын ажиллагааны төлөв байдал, Монгол улсын засгийн газрын хятадтай харилцах чиг хандлага зэрэг асуудлаар мэдээлэл олох, Улаанбаатарт суугаа Хятадын элчин сайдын яамны ажилтан Жао Вэньжунтай тогтмол уулзаж байхыг Ц.Нямдоржид сануулах, Нямдорж хятадын тагнуултай холбоотой болсноо бусдад задруулсан эсэхийг дахин нягтлан шалгах зорилготой ирсэн юм. Тэд зорилгоо биелүүлээд буцсан. Бээжингээс тагнуулын хоёр ажилтан үлэмж зардал гаргаж Улаанбаатарт томилолтоор ирж Ц.Нямдоржтой уулзсан явдал хятадын тагнуулын байгууллага Ц.Нямдоржид ихээхэн итгэл найдвар хүлээлгэснийг харуулж байгаа юм.

Энэ үеэс эхлэн Ц.Нямдорж монголын тагнуулын байгууллагын үйл ажиллагааг саармагжуулах, эрч хүчийг сулруулах, УИХ-ын шалгалтын ажлын хэсэгт орж тагнуулын газрыг шалгах нэрээр ажил төрлийг нь унагах гутаах явуулга хийх болсон юм. Ц.Нямдоржийн эдгээр явуулгууд өмнөдийн тагнуулынхны Монголын тагнуулын байгууллагыг мөхөөх стратегийн зорилготой яв цав нийцдэг юм. Үүнтэй уялдан монголын тагнуулын байгууллагыг улам бэхжүүлэх шаардлага цаг үеийн нөхцөл байдлаар тулгамдсан зорилт болсоор ирлээ. Ц.Нямдоржийн төр засгийн эрх мэдэл рүү тэмүүлэх шунал нь улам бүр буцалж эхэлсэн. УИХ-ын 2000 оны сонгуулиар тэрээр хууль хүчний байгууллагыг гартаа оруулах боломж олж авлаа. Тэрээр эрх мэдэлтэй болонгуутаа сэтгүүлчид, хэвлэл мэдээллийнхнийг эхний ээлжинд шалгаж "цэгцлэх" арга хэмжээ авсан. Дараагаар нь эрүүгийн хуулийг яаравчлан өөрчилсөн гээд дэс дараалсан олон арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Энэ мэтчилэнгийн арга хэмжээ нь Монголд хятадын тагнуул туршуул чөлөөтэй сэлгүүцэх боломжийг бий болгосон.

Ц.Нямдорж хятадын тагнуултай холбогдсон гэмт үйлдлээ нуун дарагдуулахын тулд Хууль зүй дотоод хэргийн сайдын албан тушаал эрх мэдлээ 2000-2004 онд урвуулан ашигласан. Ц.Нямдорж албан тушаал эрх мэдлээрээ далайлган төр засаг, хууль хүчний байгууллагыг зогсолтгүй ажиллуулж хятадын тагнуулд элссэнээ нуун далдалж чадсан юм. Ц.Нямдорж 2003 оны намар УИХ-ын чуулган дээр үг хэлэхдээ, "...УИХ бүрэн эрхийнхээ дагуу шүүх, прокурорыг өөртөө авч цэгцлэхийг" удаа дараа шаардсан. "УИХ онцгой эрхээ эдлэх цаг удахгүй ирж магадгүй..." гэх зэргээр мэдэгдэж прокурар, шүүхийн бүрэн эрхэнд халдаж, хууль хяналтын байгууллагын удирдлагыг дарамталж дуугүй болгож байсан нь хэвлэл мэдээллийн хуудсанаа үлджээ.

Албан тушаалдаа эрдсэн тэрээр хууль тогтоомж, бодит баримтыг мушгин гуйвуулж, хүнийг гүтгэхдээ гаргуун юм билээ. Монгол улсын эсрэг хэрэгжүүлсэн хятадын тагнуулын ажиллагааг судалж шалгахтай холбогдуулан 1985 оны 5-р сарын 14-ний өдөр боловсруулсан бичиг баримтыг мушгин тайлбарлаж, Нямдоржийг дагуулан Бээжинд аваачин 1985 оны 5-р сарын 14-ний өдөр хятадын тагнуулын хүмүүстэй уулзуулж тэдэнтэй хамтран Ц.Нямдоржийг элсүүлэх ажиллагаа явуулсан гэж надад ял тулгуулж байсан. Түүгээр барахгүй энэ асуудлаар Нямдорж өөрийгөө хохирогч хэмээн мэдүүлэг өгч, уг мэдүүлэг дээрээ "Баатар чи хэргээ хүлээ, хүлээ, эс хүлээвэл шоронд олон жилээр тарчлах болно" гэж өөрийн гараар бичсэн байдаг юм. Өөрөөр хэлбэл миний биеийг хятадын тагнуулчидтай нийлж Нямдоржийг элсүүлсэн "хэрэгтэн" болгох гэж тэрээр үнэнхүү чармайсан болно.

Ц.Нямдорж энэ мэт үйлдлээрээ өөрөө хятадын тагнуулын байгууллагад элсэгдсэнээ бүрэн хүлээн зөвшөөрсөн юм. Ц.Нямдорж 2004 оны 2-р сард "Зиндаа" сонинд ярилцлага өгөхдөө Нямдоржийн зургийг нэг хүүхэнтэй монтажилчихвал /эвлүүлчихвэл/ сайхан болно доо гэж ярьж байсан хүн бий гэсэн байдаг. Ц.Нямдорж хятад хүүхэн Тунь Шаобинтай авахуулсан зургаа хэрэв ил гарвал түүнээс зайлж бултах гарцыг урьдаас эрэлхийлсэн ядарсан арга гэлтэй. Энэ бүхэн бол тэрээр харийн туршуул болсон гэмт үйлдлээ цайруулахын тулд юу ч хийхээсээ буцахгүй байсны баримтууд болно. 2000-2004 онд Ц.Нямдоржийн үнэн бодит байдлыг хэлсэн хүн бүрт эрүүгийн хэрэг үүсгүүлж байцаалган айлган сүрдүүлж дарамталж байсан.

Ц.Нямдорж монголын хуулийг өөрийн эрх ашиг дур хүсэлд нийцүүлэн тайлбарлаж, завхаруулж байсан хүн. Ц.Нямдорж Хууль зүй дотоод хэргийн сайдаар 2000-2004 онд ажиллаж байхдаа цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх байгууллагуудын тусгай хүч хэрэгсэл, бие бүрэлдэхүүнийг хуугаар нь дайчлан Ганц худгийн шоронг хэдэн давхар бүслүүлж, гарах орох хөдөлгөөнийг 24 цагаар тас хорьж байгаад 2004 оны нэгдүгээр сарын 8-нд шорон дотор шүүх хуралдааныг хаалттай хийлгэж, Нямдоржийн хятадын тагнуултай холбогдсон асуудлыг үнэн зөвөөр мэдүүлэхээр очсон гэрчийг баривчлахаар айлган сүрдүүлж улмаар шүүх хурлын өрөөнөөс хөөн гаргаж, хуралдааныг өөрөө удирдан чиглүүлж, албан тушаал эрх мэдлийнхээ хүчээр хятадын тагнуулд элсэгдсэн хэргээсээ мултарч байсан юм.

Ц.Нямдоржийн харгис үйл ажиллагааны үр дагавраар 2000-2004 онд нийгэм бүхэлдээ айдас хүйдэст автаж, 37 онд эргээд оччихсон юм шиг уур амьсгал бүрдсэн байсныг хүмүүс мартаагүй байгаа. 1992 оноос эдүгээ хүртэл Нямдоржийн ааш араншин, үйлдэл үг яриа манай эрх баригчдыг хагаралдуулах, монгол төрийг хүчгүйдүүлэх, монголын хууль хяналт, тагнуулын байгууллагыг сул дорой байлгахад чиглэж ирлээ. Үүний цаана хэний эрх ашиг сонирхол байна вэ гэдгийг эргэцүүлэн бодох цаг нэгэнт болсон. Уг нь харийн тагнуултай холбогдсон этгээд улс төрийн орон зайгаас нэн даруй зайлуулагддаг жишиг дэлхийн том, жижиг аль ч улс оронд байдаг юм. Ц.Нямдорж бодит баримтыг мушгин гуйвуулж гүтгэхдээ гаршсан хүн. Тэрээр эрх мэдлээрээ түрий барин тал тал тийш үсчин урьдын адил гүтгэн дайрч улстөржүүлж уснаас хуурай гарахыг оролдох биз. Миний бие хятадын тагнуултай холбогдсон Нямдоржийн асуудлыг шалгуулахаар 2000 оноос эхлэн тавьсаар ирлээ. Сүүлийн үеийн зарим үйл явдлаас харахад Нямдорж харийн тусгай албаны арга технологийг гайхалтай эзэмшсэн болохоо олон нийтэд харуулж байх шиг. Тэрээр тухайн үйл явдал үзэгдлийн хамгийн эмзэг цэгийг олж нийгэмд бухимдал үүсгэн хөөрөгдөж өдөөн турхирч байна. Энэ нь төрийн болон олон нийтийн аюулгүйн тогтвортой байдлыг алдагдуулахад чиглэсэн ажиллагаа болно. Нийгэмд үүссэн зарим нэг эмзэг үйл явдлыг өлгөн авч прокурорын байгууллага руу дайрч, олон нийтийн сэтгэл зүйг төөрөгдүүлэн улс төрийн тоглолт хийж, "шударга шулуухан" гэмээр мэдэгдэл үг яриа гаргах болсны зорилго ганцхан шалтгаантай. Прокурорын байгууллага Нямдоржийн талаар гаргасан миний өргөдлийг Тагнуулын байгууллагад шалгуулахаар шилжүүлсэнд тэрээр ихээхэн өширхөж, прокурорын дотоод хэрэг, үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх, шахалт дарамт үзүүлэх замаар өөрийнхөө тагнуул туршуултай холбогдсон хэрэг явдлыг нуун дарагдуулахыг оролдож, бусдын сэтгэл санааны зовинолд дөрөөлөн арьсаа хамгаалахыг санаархаж байна. Ер нь эцсийн эцэст Монгол улсын язгуур эрх ашиг ялах уу, аль эсвэл хятадын тагнуулын байгууллагын хүчтэй дэмжлэг хүлээсэн туршуул Ц.Нямдорж ялж тэрээр олон нийтийн сэтгэл зүйг төөрөгдүүлж шударга үнэний дүрд тоглон монгол төрийн нөмөр нөөлгөнд хорогдсон хэвээр байх уу гэдэг эгзэгтэй мөч тулгараад байгааг Монголын ард түмэнд сонордуульяа. Төрийн тусгаар тогтнол, эрх чөлөөгөө сэргээсэн Олноо өргөгдсөн монгол улс цэрэг тагнуул, эдийн засгийн хүчин чадлаар тун мөхөс байсан хэдий ч хятадын тагнуулын түрэмгий үйл ажиллагааг тухай бүр илчлэн тас цохиж туурга тусгаар биеэ даасан байдлаа хадгалж чадсан түүхэн уламжлалтай билээ.

Хошууч генерал Ж.БААТАР 2017-03-31

/ТӨЛБӨРТЭЙ НИЙТЛЭВ/




## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : **2017 оны 04-р сарын 11-ны өдөр**
Тендер шалгаруулалтын нэр: **"Дүүргийн Хангамж үйлчилгээний төв хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх"**
Тендер шалгаруулалтын дугаар: **НДХААА-2017/Б-10**

**Налайх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь** эрх бүхий тендерт оролцогчдоос **"Дүүргийн Хангамж үйлчилгээний төв хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх"**-ыг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **/50,000/** тавин мянган төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Төлбөрийг Төрийн сан банк-100200455009 тоот дансанд тушаана.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **[45]** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:
- Борлуулалтын хэмжээ: **50,0 сая төгрөгөөс багагүй байна.**
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Тухайн багцын үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна.**
- Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **2016 он**
- Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **30,0 сая төгрөгнөөс багагүй байна.**
- Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Шаардлагагүй.**

Тендерийн хамт Багц 1: -1 100 000 /нэг сая нэг зуун мянга/ төгрөг, Багц 2: 750 000 /долоон зуун тавин мянган/ төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2017 оны 05–р сарын 11–ны өдрийн 10.00 цагаас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 05–р сарын 11–ний өдрийн 10 цаг 30 минутанд** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **"Тооцохгүй"**
Дотоодны давуу эрх тооцох эсэх: **"Тооцохгүй"**
Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 2-р хороо,**
**Хуульчдын гудамж, ОНӨААТҮГ байр,**
**Худалдан авах ажиллагааны алба. Утас:7023-2788**
**Цахим хаяг: www.tender.gov.mn, www.nalaikh-tender.mn**

# ДЭЛХИЙ

## Будапештэд эсэргүүцлийн жагсаал боллоо

Б.СУМЪЯА

Унгарын нийслэл Будапешт хотод энэ сарын 9-нд боловсролын хуулийн шинэчлэлтийг эсэргүүцсэн томоохон хэмжээний жагсаал болжээ. Зохион байгуулагчдын хэлж буйгаар, жагсаалд 80 мянга орчим хүн оролцсон байна.

Боловсролын хуулийн шинэчлэлттэй холбогдуулан Унгараас гаралтай АНУ-ын хүмүүнлэгийн үйлстэн Жорж Соросын үүсгэн байгуулсан Европын их сургууль хаалгаа барихад хүрсэн аж. Улмаар үүнийг эсэргүүцэн дээрх хэмжээний хүмүүс гудамжинд гарч жагссан байна.

Засгийн газрын танилцуулсан шинэ журмаар бол, Төв Европын их сургууль АНУ-д бүртгэлтэй учир төгсөгчдөд диплом өгөх эрхгүй гэнэ.

Сүүлийн гурван жилийн хугацаанд тус улсад ийм хэмжээний жагсаал болж байгаагүй юм. Европын их сургуулийн оюутан, багш нар ч энэ удаагийн жагсаалд оролцжээ. Жагсагчдын ихэнх нь сургуулийн өнгө бүхий цэнхэр өнгийн хувцас өмссөн байсны зэрэгцээ Унгарын төрийн далбаа, Европын холбооны далбаа, АНУ-ын далбаа зэргийг өргөж, дэлхийн соёлын өвийн Буда цайзаас парламентын ордон хүртэл жагсаал үргэлжилсэн байна. Мөн жагсагчид Ерөнхийлөгч Янош Адераас Ерөнхий сайд Виктор Орбаны эрх баригч Фидес намынхны санаачилсан хуульд гарын үсэг зурахгүй байхыг шаардсан байна. Дээд боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахыг тус улсын Засгийн газар өнгөрсөн долоо хоногт дэмжсэн юм. Ингэснээр унгар гаралтай тэрбумтан, санхүүч бөгөөд хүмүүнлэгийн үйлстэн Жорж Соросын 26 жилийн өмнө үүсгэн байгуулсан Төв Европын их сургууль цаашид Будапештад үйл ажиллагаа явуулах боломжгүй болжээ.

## ОРОСЫН МЕТРОНД БОЛСОН ДЭЛБЭРЭЛТ УЧИР БИТҮҮЛЭГ ХЭВЭЭР БАЙНА



Reuters

Б.ДАВАА

ОХУ-ын Санкт Петербург хотын метронд дэсрэх бодис дэлбэрч, 14 хүн амиа алдсанаас хойш долоо хоног өнгөрчээ. Гэвч, тус халдлагын ард чухам хэн байгаа нь учир битүүлэг хэвээр байна. Тухайн үед метронд 22 настай Киргиз гаралтай Акбаржон Жалилов гэгч амиа золиослон бөмбөг тэслэжээ. Улмаар цагдаагийнхан хэрэгт холбогдуулан найман хүнийг баривчилсан ч, одоогоор терроризмын үйл явц, зорилго, хэт даврагч бүлэглэлтэй холбоотой эсэх нь тодорхойгүй байна. Гэмт хэрэгтний тухайд Киргизийн өмнөд этгээдийн Ош хотод төрсөн. Түүний төрсөн нутагт лалын хэт даврагчид идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг бөгөөд метронд болсон халдлагыг "Лалын улс" бүлэглэл захиалсан байх магадлалтай гэсэн албан бус мэдээлэл байгаа юм.

ОХУ-ын Холбооны мөрдөх товчооны дарга Александр Бастрыкины хэлснээр Акбаржон Жалилов болон "Лалын улс" бүлэглэлийн хооронд ямар нэг холбоо байгаа эсэхийг нягтлах чиглэл өгч ажиллаж байгаа аж. Гэвч, өнөөдрийг хүртэл хэт даврагч бүлэглэлтэй холбоотойг нотлох ямар нэг баримт олдоогүй гэнэ.

Мөн метронд халдлага үйлдсэн гэдгээ хүлээсэн террорист бүлэглэл ч одоогоор байхгүй байгаа юм. Хэргийг шалгах багийн мэдээлснээр сэжигтэнтэй холбоотой байж болзошгүй зургаан хүнийг Санкт Петербургаас, хоёр хүнийг Москвагаас баривчилжээ. Москвагаас 38 настай Тажикистан эрэгтэй болон Узбекистанаас гаралтай эмэгтэйг баривчилсан байна. Тэднээс энэ сарын 7-нд байцаалт авсан ч, террорист халдлагад оролцоотой эсэх нь урьдын адил тодорхойгүй байна.

Гэхдээ мөрдөн байцаагчид амиа золиослосон хэрэгтний гэрт нэгжлэг хийхэд их хэмжээний зэвсэг хэрэглэл, тэсрэх бөмбөг илэрсэн бөгөөд "Хувийн хэрэглээнийх биш" байсан гэдгийг онцолж байгаа юм.

Мөн Санкт Петербургаас баривчилсан 23 настай киргиз эрэгтэй ч "Лалын улс" бүлэглэлтэй ямар ч холбоогүй болох нь тогтоогдсон байна.

Тэгвэл, "Роетерс" агентлаг уг хэргийн талаар нэрээ нууцалсан эх сурвалжийн мэдээлэлд үндэслэн сэжигтэн этгээд амиа золиослохын өмнө Туркийн хил нэвтэрч байсан тухай ярьжээ. Гэхдээ Турккээс Сири рүү явж байсан үгүйг нь тодорхой хэлж мэдэхгүй гэж ярьсан байна. Турк нь лалын хэт даврагч бүлэглэлийн хамсаатнуудын Сири рүү нэвтрэх гол зам нь болдог аж.

## Ан Чол Су санал асуулгыг тэргүүлж эхэллээ



БНСУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшиж буй Ан Чол Су сүүлд явагдсан санал асуулгаар зүүнийг баримтлагч Мун Жэ Инийг ялсан байна. "Yonhap" болон "KBS"-ээс явуулсан энэхүү санал асуулгаар Ан Чол Су 36.8, Мун Жэ Ин 32.7 хувийн санал авчээ. Ийнхүү төвийг баримтлагч, Ард түмний намын Ан Чол Су болон Ардчилсан намын Мун Жэ Ин нарыг БНСУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд хүчтэй өрсөлдөнө гэж таамаглаж байна.

Харин Ерөнхийлөгч асан Пак Гын Хэгийн Консерватив намын нэр дэвшигч сүүлийн санал асуулгаар ганц оронтой тоонд хүрэхүйц л санал авч чаджээ. Нэр дэвшигч Ан Чол Су БНАСАУ-ын эсрэг дорвитой арга хэмжээ авахыг хүсэж байгаа нь олны анхаарлыг татаж байна. Тэрбээр АНУ БНСУ-ын нутаг дэвсгэрт пуужингийн дайралтаас хамгаалах систем байгуулахыг дэмжиж байгаа юм. БНСУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалт тавдугаар сарын 9-нд болно.

## Норвегийн нийслэлд бөмбөг тэслэхийг завджээ

Норвегийн нийслэл Осло хотын төв хэсгээс тэсрэх бөмбөг олджээ. Цагдаагийнхан тэсрэх бөмбөгийг аюулгүй болгох арга хэмжээ авсны зэрэгцээ гар хийцийн бөмбөгийг биедээ авч явсан гэх хэрэгт сэжиглэн 17 настай орос хүүг баривчилсан байна.

Мөн тус улсын Аюулгүйн албаныхан онц байдлын түвшнөө нэмэгдүүлжээ. Ингэх болсон шалтгаан нь сүүлийн үед хөрш Шведийн Стокгольм, ОХУ-ын Санкт Петербург, Их Британийн Лондон зэрэг хотуудад ээлж дараалан террорист халдлага гарсантай холбоотой аж. Мөн тус улсад ч гэсэн гэмт хэрэгтнүүд халдлага үйлдэх магадлал өндөртэй тул ийнхүү аюулгүй байдлаа чангатгаж эхэлжээ.

Тэсрэх бөмбөгийг энэ сарын 8-ны өдрийн шөнө Осло хотын төв хэсэг дэх хятад гудамжнаас олжээ. Цагдаагийнхан тухайн хэсгийг хамгаалалтад авч, бар, ресторанаас хүмүүсийг яаралтай нүүлгэн шилжүүлснийхээ дараа ням гарагийн өглөө бөмбөгийг аюулгүй болгож, сэжигтнийг баривчилсан байна.

Хэргийг хариуцсан өмгөөлөгч хэлэхдээ "Хүү зүгээр л дүрсгүйтэж байсан, гэм буруугүй хүнийг баривчиллаа" гэж хэвлэл мэдээллийнхэнд мэдэгдсэн байна. Харин "Ройтерс" агентлагийн мэдээлснээр, хүү 2010 онд Норвегид ирээд орогнол хүсч байжээ.

Цагдаагийн албаны дарга Бенедикт Бьорнланд хэлэхдээ "17 настай хүү террорист халдлага үйлдэхийг завдсан эсэх нь тодорхойгүй байна. Энэ хүү Франц, Герман, Их Британид болсон халдлагуудыг дууриах гэж оролдсон байж ч магадгүй юм" гэж мэдэгджээ.

Түүний хэлснээр, аюулгүй байдлыг чангатгасан арга хэмжээ хоёр сарын турш үргэлжлэх ажээ. Баасан гарагт Шведэд болсон халдлагын дараа болзошгүй аюулаас сэргийлэн цагдаа нар бэлэн байдалд ороод байсан юм. Стокгольм хотын худалдааны төв рүү ачааны автомашин дайран орсны улмаас дөрвөн хүн амиа алдаж, 15 хүн гэмтэж бэртсэн билээ. Энэ халдлага нь 2011 онд Норвеги улсад хэт давруу үзэлт Андерс Бревик гэгч этгээд 77 хүний амь насыг хороосон аймшигт хэргээс хойш гарсан анхны халдлага юм.

## АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга ОХУ-д айлчилна

Д.Трампын засаглал Сирийн Ерөнхийлөгч Башар ал Ассадын Засгийн газарт дэмжлэг үзүүлж буй ОХУ-ын эсрэг шахалт үзүүлж эхэлжээ. АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Рекс Тиллерсон өнөөдрөөс Д.Трампын Засгийн газрыг төлөөлж анх удаагаа ОХУ-д айлчлах билээ. Гэвч, Сирийн Ассадын дэглэм энгийн иргэдийн эсрэг химийн зэвсэг ашиглаж, улмаар АНУ Сири рүү пуужин харвасан зэрэг үйл явдалтай холбогдуулан энэ удаагийн албан ёсны уулзалтын уур амьсгал хүйтэн хөндий болж болзошгүй байна.

Рекс Тиллерсон ОХУ-ын Гадаад хэргийн сайд Сергей Лавровтой уулзалт хийх бөгөөд энэ үеэр Сирид үзүүлж буй дэмжлэгээ эргэн харахыг ОХУ-аас шаардах төлөвтэй байгааг эх сурвалжууд мэдээлж байна.

Гэвч ОХУ-ын тал Ассадын дэглэм химийн зэвсэг ашигласан гэдгийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж байгаа. Тиймээс уулзалт ширүүн маргаан, мэтгэлцээний дунд өрнөх магадлал өндөр байна.

Мөн Р.Тиллерсон айлчлалын үеэр тус улсын Ерөнхийлөгч В.Путинтай уулзах эсэх нь хараахан тодорхойгүй байгаа бөгөөд түүний айлчлалын үр дүнг ч урьдчилан тооцох боломжгүй байгааг олон улс судлаачид онцоллоо. 2013 онд АНУ, ОХУ Сирийн химийн зэвсгийг халах хэлэлцээрт тохиролцоонд хүрсэн байдаг. Гэвч химийн зэвсэг ашигласанг ОХУ үл зөвшөөрч буй нь тус хэлэлцээрийг зөрчөөд зогсохгүй "ОХУ олон улсын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхгүй" байгааг АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга мэдээлж байсан юм.ОХУ-ын тал ч Сирийн агаарын орон зайд АНУ, Оросын цэргийн онгоцууд санамсаргүй байдлаар мөргөлдөхөөс зайлсхийх зорилгоор довтолгооноо зогсоохыг сануулж буй.

Ямартай ч, энэ мэт асуудлаас үүдэн Ерөнхийлөгч Д.Трампын хэт даврагч "Лалын улс" бүлэглэлийн эсрэг дайнд хамтрах төлөвлөгөө биелэхэд бэрхшээл тулгарч болзошгүй байна.



ЦАГ ҮЕ

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ



# Ч.ЭНХБАТ: 300 САЯ ТӨГРӨГӨӨР ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙГ САНХҮҮЖҮҮЛНЭ

*Дархан-Уул аймгийн удирдлагууд 2017 онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхээр хоёр зорилт дэвшүүлсний нэг нь Шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэд, төрийн бус байгууллага, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх явдал юм. Энэхүү зорилтын хүрээнд “Төр, нийгмийн түншлэл-2017” аймгийн зөвлөгөөнийг зохион байгуулж, төр болон төрийн бус байгууллагууд нэгэн дээвэр дор цуглан тулгамдсан асуудлууд, цаашдын хамтын ажиллагааныхаа талаар хэлэлцлээ. Зөвлөгөөний үеэр аймгийн ЗДТГ-ын дарга Ч.Энхбаттай уулзаж, ярилцлаа.*

**-“Төр нийгмийн түншлэл” аймгийн зөвлөгөөнийг зохион байгуулж байна. Зөвлөгөөнөөс ямар үр дүнг хүлээж байна вэ?**

-“Хөгжлийн төлөө түншлэл” уриатай энэхүү зөвлөгөөнөөс олон эерэг үр дүнг хүлээж байгаа. Зөвлөгөөнд 38 төрийн байгууллага, 82 төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий нийт 120 төлөөлөгч оролцлоо. Бид зөвлөгөөнийг уггтаж, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдээс хамтран ажиллах саналыг албан бичгээр, нээлттэй утсаар, цахим хуудсаар дамжуулан хүлээн авсан. Холбогдох саналуудыг аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр төслүүдэд тусгаж, төрийн болон ТББ-уудтай хамтран ажиллах хамтын хэлэлцээр, гэрээ, санамж бичиг байгуулж ажиллахаар болсон нь хамтын ажиллагааны зорилго, үр дүнгээ хамтдаа тодорхойлж баталгаажуулсан үйл явдал боллоо. Цаашид эдгээр санамж бичгүүдээ хоёр талаас бодит ажил хэрэг болгоход аль аль тал нь анхаарчихвал бидний зохион байгуулсан зөвлөгөөний үр дүн гарна гэж хүлээж байна.

**-Энэ удаад ТББ-уудаа бүртгэлжүүлж авсан байх. Аймгийн хэмжээнд идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй хэчнээн ТББ байна вэ?**

-Монгол Улсын хэмжээнд 15 мянга гаруй ТББ бүртгэлтэй байдаг бөгөөд үүнээс Дархан-Уул аймгийн хэмжээнд статистикийн тоон мэдээгээр 450, Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 398, улирлын тайлан балансаа гарган тогтмол үйл ажиллагаа явуулдаг Татварын хэлтэст бүртгэлтэй 43 төрийн бус байгууллага байдаг гэсэн дүн гаргасан. Эдгээр байгууллагууд 32 чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна гэсэн судалгаа бий. Өөрөөр хэлбэл, Дархан хотын хөгжлийн төлөө, нийгмийн сайн сайхны төлөө зүрх сэтгэлээ гаргаж байнгын идэвхтэй ажилладаг 40 гаруй ТББ байна.

**-Ер нь аймгийн ЗДТГ өнгөрсөн хугацаанд төрийн бус байгууллагуудтай хэрхэн хамтарч ажиллаж ирсэн бэ?**

-Аймгийн ЗДТГ-аас өнгөрөгч 2016 онд төр иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд есөн ТББ-д 88.2 сая төгрөгийн санхүүжилт олгож, аймаг орон нутгийн тулгамдсан асуудлыг хамтдаа шийдвэрлэн ажилласан байна. Мөн төсөв хөрөнгө гэхгүйгээр итгэл, сэтгэл, зүгтэлээр нийгмийн шинжтэй олон ажлуудыг ТББ-уудынхаа дэмжлэг тусламжтайгаар хамтран шийдвэрлэсэн. Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа ч иргэд, төрийн бус байгууллагуудынхаа саналыг авсан. “Дарханы хөгжил-Иргэний нийгмийн байгууллагуудын бүтээлч санаачилга, идэвхитэй оролцоо”, “Төр, нийгмийн түншлэл” сэдвүүдээр аймгийн ИТХ-ын дэргэдэх “Иргэний танхим”-тай хамтран нээлттэй хэлэлцүүлгийг хоёр удаа зохион байгуулж, нийт 28 ТББ-аас ирсэн 50 гаруй саналыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Цаашид ч төр иргэний нийгмийн түншлэлийг улам өргөжүүлж, “Соёлын бүтээлч үйлдвэрлэл түншлэл 2017” нэгдсэн форум, хүүхэд, залуучууд, ахмадуудын тэр дундаа эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дуу хоолой болсон тэдний эрх ашгийг хамгаалдаг тэр чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ыг хамруулсан зөвлөгөөнүүдийг тус тусад нь зохион байгуулахаар төлөвлөж байна.

**-Уулзалт зөвлөгөөнөөс гадна хөрөнгө санхүүгийн хувьд ямар дэмжлэг үзүүлэх вэ?**

-Төрийн захиргааны байгууллагуудаас ТББ-тай зөвлөлдөх, хамтран ажиллах нь чухал байгаа юм. Бүтээлчээр оролцдог, олон нийтийн санаа бодол, хүсэл зоригийг нийтийн үйл хэрэгт дайчлан зохион байгуулж чаддаг ТББ-уудын чадавхийг нэмэгдүүлэхэд анхаарна. 2017 онд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах 300 сая төгрөгийг аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, зарцуулах эрх авсан. Ингэснээр ТББ-уудтайгаа хамтран аймаг, орон нутгийн төсөв болон Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулж, хамтарч ажиллана гэсэн үг. Энэ хүрээнд сонгон шалгаруулах журамдаа нэмэлт өөрчлөлт оруулж, зөвлөгөөний үеэр танилцууллаа. Уг журмаар хөрөнгө оруулалтын нийт зардлын 70 хувиас дээш нь капиталжих буюу биет эд, зүйлс, 30 хүртэлх хувь нь биет бус байхаар тусгагдсан. Мөн тухайн үйл ажиллагааг нэг жилээс доошгүй хугацаанд эрхэлсэн дадлага туршлагатай, олон нийтэд танигдсан байх, татварын болон банкны зээлийн хугацаа хэтэрсэн өр, зээлгүй байх зэрэг шаардлагыг хангасан төслийг сонгон шалгаруулах юм.

**-Төрийн бус байгууллагуудаас ихэвчлэн ямар ажлуудад хамтарч ажиллах саналууд гарав?**

-Сургалт, судалгаа, сурталчилгаа, хяналт, үнэлгээний ажлыг ТББ-уудаар гүйцэтгүүлж, шаардагдах хөрөнгө санхүүжилтийг нь орон нутгийн төсөвт тусгаж, санхүүгийн дэмжлэг үзүүлдэг байх саналыг уулзалтад оролцогчдоос гаргаж байсан. Нөгөө талаас төрийн байгууллагуудаас маш олон саналыг ТББ-уудад тавьсан. Тухайлбал, Дархан сумын ЗДТГ-аас зорилтот бүлгийн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ая тухтай амьдрах орчинг бүрдүүлж, эрүүл мэндийг сайжруулах, орон гэртэй болгох зорилгоор сайн үйлсийн аяныг хамтран зохион байгуулах бол Хонгор сумын ЗДТГ-аас сум орны хөгжилд ахмадуудын оролцоог нэмэгдүүлэх нийт найман ажлын саналыг ирүүлсэн. Аймгийн ХХҮГ-аас хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй ажилгүй, мэргэжилгүй иргэдэд мэргэжлийн болон давтан сургалт, үйлдвэр дээрх сургалтыг зохион байгуулах, хөдөлмөр эрхлэлтийн мэдээ, мэдээллээр хангаж, эрэлт, хэрэгцээнд тулгуурлан ажилгүй иргэдийг ажилд зуучлах үйлчилгээг зохион байгуулах ажлуудыг ХХҮЕГ-аас эрх авсан төрийн бус байгууллагууд болон аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран зохион байгуулахаар төлөвлөсөн байна. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас өөрийн үндсэн чиг үүргийн дагуу гэр бүл, хүүхэд, залуучууд руу хандсан хөгжүүлэх, мэргэшүүлэх сургалтуудыг хамтран зохион байгуулах чиглэлээр 18 ажлын саналыг ирүүлсэн бол ЭМГ-аас сувилагч нарыг чадваржуулах, цус цусан бүтээгдэхүүний нөөцийг нэмэгдүүлэх зэрэг нийт таван ажлын санал тавьсан. Энэ мэтчилэн төр залуурдаж, харин сэлүүрдэх үүргийг түншлэгч ТББ-уудад шилжүүлье, хамтран ажиллая гэсэн сайн санаачилгууд зөвлөгөөний үеэр өрнөсөнд оролцогчид маань талархалтай байна.

**-Та ярилцлагын эхэнд ТББ-уудтай хамтарч ажиллахаар санамж бичгүүд байгуулсан тухай дурьдлаа. Тухайлбал ямар ямар ажлуудыг хийх юм бол?**

-Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар, сумдын ЗДТГ, хэлтэс агентлагуудаас иргэн, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллахаар ирүүлсэн 110 санал боломж, иргэн, ТББ-уудаас төрийн байгууллагуудтай хамтран ажиллахаар ирүүлсэн 70 гаруй саналыг нэгтгэн 12 ТББ-тай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан. Тухайлбал, JCI Дархан салбар, Монголын спорт аяллын холбооны Дархан салбар, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын нэгдсэн холбоо, ХААИС-ийн дэргэдэх “Бизнес судлал, сургалтын төв” ТББ, Дарханы оюутны холбоо, “Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо”-ны Дархан дахь салбар, аймгийн Ахмадын хороо, Ахмад багш нарын холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоодтой хамтарч ажиллахаар болсон. Мөн хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх нийгэмд эерэг нөлөөлөл үзүүлэх зорилго бүхий “Инээмсэглэх Дархан” төслийг JCI Дархан салбартай хамтарч хэрэгжүүлнэ. Зорилтот бүлэгт чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй хүргэх, хүүхдийн шүдний үзлэг эмчилгээг төлбөрийн хөнгөлөлттэй үнээр үзүүлэх ажлыг хувийн хэвшлийн ЭМБ-уудын нэгдсэн холбоотой хамтарч хийнэ. Түүнчлэн Дархан-Уул аймгийн Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт 2017-2018 оны хэлэлцээрт аймгийн Засаг дарга, Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Ажил олгогч эздийн холбооны дарга нар гарын үсэг зурж баталгаажууллаа. Хэлэлцээрт хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн асуудал, цалин хөлс, нийгмийн хамгаалал, нийгэм эдийн засаг, нийгмийн түншлэл гурван талт тогтолцоог хөгжүүлэх зэрэг иргэд хөдөлмөрчдийн эрх ашигт нийцүүлсэн асуудлыг тусгасан.

> ...Монгол Улсын хэмжээнд 15 мянга гаруй ТББ бүртгэлтэй байдаг бөгөөд үүнээс Дархан-Уул аймгийн хэмжээнд статистикийн тоон мэдээгээр 450, Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 398, улирлын тайлан балансаа гарган тогтмол үйл ажиллагаа явуулдаг Татварын хэлтэст бүртгэлтэй 43 төрийн бус байгууллага байдаг гэсэн дүн гаргасан...

Аймгаас мэдээлж байна

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

## “Иргэдээ сонсоё” аяныг зохион байгуулав

Говьсүмбэр аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан “Хуулийн байгууллагуудын үйлчилгээний чанарыг сайжруулах, иргэдэд эрх зүйн мэдлэг олгох дэд хөтөлбөр”-ийн хүрээнд аймгийн хуулийн байгууллагууд хамтран “Иргэдээ сонсоё” аяныг энэ сарын 05-06-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тус аянд аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, Цагдаагийн хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Шүүхийн шинжилгээний алба, Шүүхийн Тамгын газар, Прокурорын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, нотариат, аймгийн өмгөөлөгчдийн зөвлөл, Хүний эрхийн үндэсний комиссын Говьсүмбэр аймаг дахь төлөөлөгч, нийт 45 хүний бүрэлдэхүүнтэй баг Шивээговь, Баянтал сумдад ажиллаж иргэдэд өөрсдийн байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогоо сурталчлан таниулж, санал хүсэлтийг хүлээж авч, иргэний бүртгэл, нотариатын үйлчилгээ үзүүлж, хууль, эрх зүйн зөвлөгөө туслалцаа үзүүлэн, хуулийн байгууллагын албан хаагчдаас урлагийн тоглолт хүргэж, иргэдийн дунд энгийн болон хууль, эрх зүйн мэдлэг шалгасан “АХА” тэмцээнийг зохион явуулсан байна.



## Шивээговь сумын “Цэвэрлэх байгууламжийн шинэчлэл” хэлэлцүүлэг боллоо

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын ундны усны аюулгүй байдал, өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, цэвэрлэх байгууламжийг барьж байгуулах ажлын талаар оновчтой шийдэл бий болгох холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулж, удирдан зохион байгуулах зорилгоор аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Умард говийн гүвээт-халхын дундад талын сав газрын захиргаа хамтран тус хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Ус сувгийн удирдах газар, аймгийн ЗДТГазар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргаа, Мэргэжлийн хяналтын газар, Барилга хот байгуулалтын газар, Эрүүл мэндийн газар, Шивээговь сумын ЗДТГ, Илчлэг Шивээ ОНӨҮГ-ын төлөөллүүд оролцлоо.

БУЛГАН АЙМАГ

## “Хөгжлийн хөтөч” форум болов

Булган аймгийн Засаг даргын Тамгын газар эдийн засгийн хөгжлийнхөө бодит байдалд тулгуурлан ирээдүйн бодлого, гарцаа тодорхойлохын тулд “Хөгжлийн хөтөч” эдийн засгийн форумыг зохион байгууллаа. “Булган аймгийн хөгжлийн бодлого”, “Булган аймгийн бизнес, эдийн засгийн салбарын өнөөгийн байдал, цаашдын хандлага” мэдээллийг аймгийн Засаг даргын орлогч Ц.Бат-Өлзий, “SICA” ХХК-ийн захирал Г.Эрдэнэ нар хийж, “Хөдөө аж ахуйн хөгжил ба жижиг, дунд үйлдвэрлэл”, “Соёлын үйлдвэрлэл ба аялал жуулчлал”, “Дэд бүтэц, тээвэр, ложистик”, “Үйлдвэрлэлийн кластер ба бүсчилсэн хөгжлийн бодлого” сэдвээр салбар хуралдаан болж форумын төлөөлөгчид санал бодлоо солилцлоо. Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан, геологи, эрдэс зүйн ухааны доктор Ч.Хурц, ШУТИС-ийн профессор, хот төлөвлөлтийн архитектор Я.Шархүү болон ХХААХҮЯ, БОАЖЯ, ОХУ-ын Красноярск муж, Туркийн хамтын ажиллагаа, зохицуулах агентлаг ТИКА байгууллага, Орхон аймаг, нийт сумын удирлага, бизнес эрхлэгчдийн төлөөлөгчид энэ форумд оролцсон юм. Энэ үеэр “Булган аймгийн хөгжлийн гарцыг тодорхойлоход энэ форумын гол ач холбогдол оршиж байгаа. Эдийн засгийн хөгжлийн талаарх бодлогоо бизнес эрхлэгчдэд танилцуулж, хамтран ажиллана. Цаашдын хөгжлийн бодлого, төлөвлөлтөө хийх, хандлагаа тодорхойлоход шинжлэх ухаан, бизнесийн төлөөллийн санал бодлыг сонсоход чиглэлээ” гэж аймгийн Засаг даргын орлогч Ц.Бат-Өлзий ярьлаа.

ДОРНОГОВЬ АЙМАГ

## Иргэний нийгмийн байгууллагуудтай сар бүр хамтран ажиллаж эхэллээ

Дорноговь аймгийн ИТХ-ын Ажлын албанаас орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, сар бүр тэдний санаа бодлыг сонсож эхэлжээ. Энэ сарын 07-нд зарим төлөөлөлтэй уулзаж хийхээр төлөвлөсөн ажлаа танилцуулав. ИТХ-аас энэ сард хувь хүний хөгжлийн асуудлаар сургалт, “Иргэн-гэр бүл ба эрх үүрэг” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулахаар төрийн бус байгууллагуудын төлөөлөлтэй тохирчээ. Мөн иргэдтэй хамгийн ойр ажилладаг багийн хэсгийн ахлагч нарыг чадавхижуулах сургалтыг ч хамтран зохион байгуулахаар шийдсэн аж. Уулзалтын үеэр иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд сонирхлын бүлгүүдийг дэмжих, олон талт сургалт сурталчилгаа зохион байгуулах, Иргэний танхимын ашиглалтын талаар тодорхой санал дэвшүүлж харилцан ярилцлаа. Дашрамд дурьдахад, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2011 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан Иргэний танхимын ажиллах журмыг шинэчилж батлуулахаар Ажлын албанаас төсөл боловсруулснаа энэ үеэр танилцуулж, төрийн бус байгууллагын төлөөллүүдээс санал авав. Дорноговь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 40 гаруй төрийн бус байгууллага байдаг аж.

NO STRESS

Улаанбаатарт:

Маргааш

Өдөр +14
Шөнө -4

Нөгөөдөр

Өдөр +16
Шөнө -1

## Өдрийн зурхай

**ХАВРЫН ДУНД ХАРАГЧИН ТУУЛАЙ САРЫН ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ШАР ЛУУ ӨДӨР**

**Үс засуулбал:** *Өлзийтэй сайн*

**Наран ургах, шингэх:** *06.15-19.34*



Тухайн өдөр хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын абшиг авах, шинэ гэр ба байр авах, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлахад сайн. Гүүр тавих, газар ухах, эрдэнийг гадагш өгөхөд муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар явaар одогсод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал өлзийтэй сайн.

## Бидэнд тохиолдсон хүндхэн хөгтэй явдлууд

**Б' Жаргал**



Боловсрол суваг телевизийн "Яг түүн шиг" шоуны дараа гэрт бөөн хөгтэй зүйл болох юм даа. Аав "Ариунцэцэг үнэхээр үзэсгэлэнтэй хүүхэн юмаа. Бие хаа гэж ярих юм алга" гэв.

Тэгтэл ээж "Тэгээд сайхан бие хаатай Ариунаатайгаа суугаач. Чамаас салчихвал Гантогоо гэж сайхан залуу байна надад" гэнэ ээ. Бас "Чамаас хэд дахин эгдүүтэй, сэтгэл нь цагаахан " гэнэ шүү. Ха ха ха

ОДДЫН ЦАГ



Орчуулсан: Б.ДАВААХҮҮ

*"Ghost in the shell" буюу "Хуягт сүнс" кино дэлхий даяар нээлтээ хийгээд эдүгээ "Тэнгис" кино театрын дэлгэцнээс үзэгчдэд хүрч буй билээ.Тус бүтээлийг 1989 онд гарч байсан "Манга" цувралаас сэдэвлэн бүтээжээ. 2014 онд гарсан "Lucy"-ийн үргэлжлэл "Хуягт сүнс" киноны гол дүрийн робот цагдаагийн дүрд холливудын үзэсгэлэнт жүжигчин Скарлетт Йоханссон тоглосон байна. Найруулагч Руперт Сандерс дүүрэн адал явдлаар үргэлжлэх уг бүтээлдээ дорнын соёл тэр дундаа Японы Якуза нарын хувцас хэрэглэл, дүр төрхийг түлхүү шингээж өгчээ. Ингээд уг бүтээлийн талаар дэлгэсэн Скарлетт Йоханссоны ярилцлагыг орчуулан хүргэж байна.*

# СКАРЛЕТТ ИОХАНССОН:

## "Хуягт сүнс" киноны анимэйшныг үзээд, ойлгоогүй

**-"Gost in the shell" киноны гол дүрд тоглосон. Бэлтгэлээ хэрхэн хангав?**

-Эхлээд "Gost in the shell" киноны оргиналь хувилбар буюу анимэйшныг нь үзсэн. Гэхдээ үнэнийг хэлэхэд, яг юуны талаар өгүүлж байгааг нь сайн ойлгоогүй. Маш нарийн тооцож хийсвэрлэсэн тус зохиолыг бодит болгохдоо өөрийн дүрээ яаж гаргах вэ гэж сайтар эргэцүүлсэн. Тэгээд найруулагч Руперт Сандерстай дүрийнхээ талаар удтал хэлэлцсэнийхээ дараа, түүнээс уул овоо мэт их материал авч судалсан даа. Тэр дүрээ гаргахад тусалсан гэж бодож байна. Дүрээ хэрхэн гаргах вэ гэж шаналж, найруулагчаасаа судлах материал авч байсан тохиолдол энэ удаа хоёр дахь нь. Өмнө нь "Люси"-д тоглож байхдаа мөн л маш их материал судалж байлаа. Мэдэхгүй учраас ойлгомжгүй зүйл их байсан. Түүнчлэн, оргинал анимэйшн хувилбар нь хүмүүсийн сэтгэлд нэгэнт хүрчихсэн байсан учраас бодитжуулан дэлгэцийн бүтээл болгоход өндөр хариуцлага надад ногдож байлаа. Тиймээс зураг авалтад орохын өмнө цуглуулсан материал, ном зохиол уншиж, өөрийн гэсэн ойлголттой болсон. Энгийнээр хэлбэл, "Gost in the shell" зохиол кибер терроризмын эсрэг тэмцэж буй робот цагдаагийн тухай өгүүлдэг юм.

**-Адал явдалт үзэгдэлд тоглох ч гэсэн хэцүү байсан байх. Кинонд тоглохын тулд тусгайлан бэлтгэл хийсэн тохиолдол бий юу?**

-Бие мах бодийн бэлтгэлийн тухайд хувийн дасгалжуулагч авч, өглөө бүр тогтсон цагт бэлтгэл хийдэг байсан. Түүнээс биш, киноны үзэгдэлд зориулан тусгайлсан бэлтгэл хийсэн удаагүй. Яах вэ, зураг авалт эхэлсний дараа өөрт зориулах цаг багассан. Өглөө зураг авалтын талбайд ирээд, орой харуй бүрийд харих үе ч байлаа. Ер нь ямар ч адал явдалт кинонд тоглоход ийм л байдаг. Гэхдээ энэ кинонд бодит орон зайн хэмжээгээ тооцох, жижиг хэрэглэлүүдээ хэрхэн гаргах зэрэг ойлгомжгүй зүйл их байсан. Тийм учраас студидээ очоод бүжиг дэглээчийн хамт сургуулилт хийдэг байлаа. Хамгийн хэцүү нь шөнийн клубт зодолддог хэсэг. Маш давчуу газарт гурван залуутай зодолдож зураг авахуулах тун хэцүү байж билээ. Цаг хугацааг зогсоож болдог байсан бол тэр үед би усан санд өөрийгөө гавлачихмаар байсан /инээв/. Тэр хэсгийн зураг авалтад ямар ч орлон тоглогчгүй, өөрөө тоглосон юм л даа. Хамгийн хэцүү нь энэ байсан юм байна.

**-Хагас робот цагдаа Мира өөрийгөө хүн эсвэл робот гэдгээ ялгахаа больдог. Энэ тус бүтээлийн нэг чухал сэдэв нь. Хийсвэр ухагдахуун хэдий ч, үүнийг яаж ойлгон, хэрхэн жүжиглэсэн бэ?**

-Тийм шүү, миний дүрийн хамгийн хэцүү нь энэ. Эхэндээ бол яаж гаргах учраа олохгүй байлаа. Гэхдээ янз бүрийн материал уншиж судалсны дараа Фрейдийн зүүдний онол миний гаргах дүртэй таарч байгааг мэдсэн. Хүний оюун санааны гурван чухал ойлголт буюу "Ид / хүнд төрөлхөөс нь байдаг инстинкт маягийн оюун санаа/, Эго /хувь хүнд зөвхөн өөрт нь байдаг орчин нөхцөлөөсөө олж авсан ойлголт – ухамсар/, супер эго /нийгэмд байгаа хүмүүст нэгэн утгатай ойлгогддог тэр зүйл/-г ойлгодог болмогцоо бүсгүй өөрийгөө олж эхэлдэг. "Би хаана байгаа, ямар үйл ажиллагаа эрхэлдэг вэ" гэдгээ ухамсарласан хэрэг. Эцэст нь, хүний ухамсар гэдэг дадал, туршлагаас бий болдог гэдгийг ойлгосон. Мирад ч гэсэн өнгөрсөн хугацааны дурсамж, дадал бий. Тэр нь зохиолын гол сэдэв байсан. Бүсгүй хагас робот хэдий ч, өнгөрсөн дурсамж нь ой санамжид хадгалагдаж байдаг. Энгийн хүн бол өнгөрснөө шууд л санана. Харин робот цагдаагийн хувьд ууpаг тархи, бие махбодь хоёрынх нь хооронд тодорхой зааг бий. Үүнийг ойлгосны дараа "өөрийгөө ойлгохоо болих" тэр мэдрэмжийг мэдэрч буй бүсгүйн дүрийг бүтээх айдас багассан. Иймэрхүү байдалд хэдэн долоо хоног жүжиглэсэн чинь сүүлдээ дадал болох шинжтэй болсон шүү /инээв/.

**-Олон хүнд хүрсэн, алдартай хүүхэлдэйн кино гэдгийг нь мэднэ. Гэхдээ нөгөөтэйгүүр, оргинал эх хувилбарыг нь мэддэггүй залуус олон байдаг шүү дээ?**

-Тэр тусмаа өндөр хариуцлага шүү дээ /инээв/. Одоогийн залуус хуучны уран бүтээлийн мэдэхгүй байгаа нь тэдний буруу биш. Бүгд тогтсон үзэл баримтлалтай байна гэдэг угаасаа бараг боломжгүй. Миний хувьд манга бүтээлийг бодитжуулсан "Хуягт сүнс" киног үзсэн хүмүүс, оргинал хувилбарыг нь шимтэгсэд киног хэрхэн хүлээж авах бол гэдгийг мэдэхийг хүсч байна. Шинэ уран бүтээл маань тэдний сэтгэлд бүрэн гүйцэд хүрч чадсан уу гэдгийг бас мэдмээр байна.

ДУУЛГАХ СОНИН

## Г.Алтанбагана түрүүлж, Б.Мөнхтуяа хүрэл медаль хүртлээ

Туркийн Анталия хотноо жүдо бөхийн гран при ангиллын тэмцээн болж өндөрлөлөө. Тэмцээний сүүлчийн өдөр хүнд жингийнхэн барилдаж, манай хоёр бөх алт, хүрэл медаль хүртлээ. Эрэгтэйчүүдийн 90 кг-д хүч үзсэн Г.АлтанбаганафиналдТажикстаны бөх Устпорийон Комроншохтай барилдаж, сүүлчийн зургаан секундэд базари үнэлгээ авснаар ялж, алтан медаль хүртлээ. Манай бөх энэ өдөр дөрөв ялж, алтан медалийн тавцанд зогссон юм. Тэгвэл эмэгтэйчүүдийн +78 кг-д барилдсан Б.Мөнхтуяа дөрвөн Турктэй барилдаж, гурвыг нь ялснаар хүрэл медалийн тавцанд зогссон юм. Манай бөх эхний хоёр тойрогтТуркийнбөхчүүдийгялсан ч хэсгийн аваргын төлөө Саяит Кайраг бараагүй. Харин хүрлийн төлөө Акбулут Себилетэй тулж, базари үнэлгээгээр ялснаар медалийн тавцанд зогссон юм. Ийнхүү Анталиягийн гран при тэмцээнд манайхаас 11 тамирчин оролцож, зургаа нь медалийн тавцанд зогслоо. Мөн нэг алт, таван хүрэл медальтайгаар багийн дүнгээр тавдугаар байрт шалгарсан юм.

## Австрид морин хуур хөгжим заана



Австри улсын Вена хотын Ф.Шубертын нэрэмжит Консерваторийн оюутан, морин хуурч Б.Санжаажавын санаачилгаар монгол үндэсний морин хуур хөгжмийг тус сургуулийн сургалтын системд нэвтрүүлж, морин хуурын дөрвөн жилийн сургалттай бакалаврын зэрэг олгох анги нээхээр болжээ.

Морин хуурч Б.Санжаажавт тус консерваторийн захирал хатагтай Даниела Эгг хамтын гарын үсэг зурсан эрх, гэрээг гардуулсан талаар тэрээр өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдээллээ.

Монгол Улсын ХБК-ийг морин хуурч мэргэжлээр төгссөн тэрээр эдүгээ тус сургуульд урлаг судлалын чиглэлээр суралцдаг. Дэлхийд нэр хүндээр тэргүүлэгчдийн эгнээнд жагсдаг тус сургуулийн сургалтын системд морин хуур хөгжмийг багтаахын тулд тэрээр дөрвөн жилийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг сургуулийн сургалтын хөтөлбөртэй нийцүүлэн боловсруулж төсөл өргөн барьсан байна. Төслийг Консерваторийн сургалтын алба, Удирдах зөвлөл хэлэлцээд дээрх шийдвэрийг 2017 оны хоёрдугаар сард гаргажээ.

Ингэснээр Монгол Улсаас болон дэлхийн өнцөг булан бүрээс монголын болон гадаадын оюутнууд Франц Шубертын нэрэмжит консерваторид нарийн мэргэжлийн хөгжмийн боловсрол эзэмшээд зогсохгүй "Морин хуур" хөгжмөөр бакалаврын зэргийг хамгаалан төгсөх бүрэн боломж нээгдэж буй юм. Мөн гадаадын оюутнууд монголын үндэсний хөгжмийг суралцаад зогсохгүй монголын соёл, урлагтай танилцан суралцах боломжтой болж байна.

GODSEND эмнэлэг

МАНАЙ ЭМНЭЛЭГ ТҮРҮҮ БУЛЧИРХАЙН АРХАГ ҮРЭВСЛИЙГ ЭМЧЛЭХ ХАМГИЙН СҮҮЛИЙН ҮЕИЙН АППАРАТААР ЭМЧИЛГЭЭ ХИЙЖ ЭХЭЛЛЭЭ



1. Эмчилгээний горим ба үйлчилгээ:

-Түрүү булчирхайд шууд хүрч, хасах цахилгаан цэнэг дамжуулах аргаар эмчилнэ
-Эмийн бодисын үйлчилгээг сайжруулж, эмчилгээний үр дүнг нэмэгдүүлнэ
-Эд эсийн бодисын солилцоо болон цус тунгалагийн шингэний урсгалыг идэвхжүүлнэ
-Биеийн дархлааг сэргээнэ
-Түрүү булчирхайн эд эсийн эмгэг өөрчлөлтийг зогсоож, эрүүл эд эсийг нөхөн төлжилтийг хурдасгана
-Түрүү булчирхайд шулуун гэдэс ба шээдэг сувээр шууд хүрч үйлчилнэ

2. Эмчилгээний заалт:

-Удаан жил үргэлжилсэн архаг явцтай түрүү булчирхайн үрэвсэл өвчинд эмчилгээний үр дүн маш сайн
-Харин түрүү булчирхайн хурц үрэвсэлтэй хүмүүст эхлээд үрэвслийн эсрэг эмчилгээ 7-10 хоног хийсний дараа энэ аппаратаар эмчлэхэд эмчилгээний үр дүн маш сайн байдаг ба өвчин архагшихгүй

3. Аппаратын давуу тал:

-Цахилгаан соронзон орны төвлөрлөөр түрүү булчирхайн бүх үе давхаргад шууд үйлчилж, төв мэдрэлийн тогтолцоонд цочрол өгснөөр тархины гадаргуугаас эфидрин их хэмжээгээр ялгардаг бөгөөд ингэснээр түрүү булчирхайн өвдөлт үрэвслийг намдааж эмчилнэ.

4. Хориглох заалт:

-Зүрх судасны архаг эмгэгтэй, цусны даралт өндөр, чихрийн шижинтэй, унаж татдаг хүмүүс, мэдрэлийн гаралтай давсагны эмгэгтэй, шээсний замын болон түрүү булчирхайн чулуутай, биед ясны хадаас гэх мэт металл суулгасан, шээсний сүвний нарийсалтай, халуунд хэт мэдрэг, 20-иос доош насны хүмүүст хэрэглэхийг хориглоно.

Утас: 80123807, 88780665
Хаяг: Улсын I төв эмнэлгийн ард, "Авзага трейд"-ийн 6 давхарт 600 тоот
И-мэйл: GODSENDHOSPITAL@GMAIL.COM

# ЦАГААН САР

# ОРОН НУТАГ

# ЦАГ ҮЕ

# ЗАВСАРЛАГА

Улаанбаатарт:



Маргааш

Өдөр -2
Шөнө -15



Нөгөөдөр

Өдөр -3
Шөнө -14

## Өдрийн зурхай

**ӨВЛИЙН АДАГ ЦАГААГЧИН ҮХЭР САРЫН НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ХАР МОРЬ ӨДӨР**

**Наран ургах шингэх:** 07.40-18.29

**Үс засуулбал:** Хэрүүл тэмцэл ирнэ.



Тухайн өдөр нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эрэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлд шамдах, бүтээл туурвил эхлэх, худалдаа арилжаа хийх, бизнэс эхлэх, зэрэг дэвших, угаал үйлдэх, тангараг тавих, гэр бүрэхэд сайн. Хэрүүл тэмцэл хийх, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ШИНЭ НОМ

УРАН БҮТЭЭЛЧ